

**Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлд иргэн, байгууллагуудаас ирүүлсэн саналын товъёог**

Д/д	Байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх
1.	Улсын Дээд шүүх 2020.10.14 1/4100	Тусгайлан гаргах саналгүй болно.	Хуулийн төслийг дэмжсэн.
2.	Хүний эрхийн үндэсний комисс  2020.10.07 3/629	<p>1.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн”, хуулийн 25 дугаар зүйлд “Иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшиглүүлж болно” гэж тус тус заасан. Иймээс төрийн бэлгэ тэмдгийг согтууруулах ундааны нэр, лого, барааны тэмдэг, зурагт ашиглахыг хориглох талаар хуулийн төслийн 32 дугаар зүйлд нэмж тусгах;</p> <p>2.Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “Төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахаас бусад тохиолдолд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно” гэжээ. Төрийн аливаа ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд согтууруулах ундааны зүйлээр үйлчлэхийг хязгаарлах нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн албаны манлайллыг бүрдүүлэх ач холбогдолтой юм. Иймээс хуулийн төслийн энэхүү заалтад заасан “Төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахаас бусад тохиолдолд...” гэснийг хасах;</p> <p>3.Хуулийн төслийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэгт “Архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус байгууллагыг төрийн бодлогоор дэмжинэ” гэж зохицуулсан боловч эдгээр байгууллагыг төрийн бодлогоор хэрхэн дэмжиж ажиллах нь тодорхойгүй</p>	<p>1.Саналыг тусгасан.</p> <p>2.Төрийн байгууллагад ёслол хүндэтгэлийн зарим арга хэмжээнд тодорхой зориулалтын согтууруулах ундаа хэрэглэх шаардлага үүсдэг тул саналыг хүлээж аваагүй болно</p> <p>3.Саналд туссан асуудал хуулийн төслийн хүрээнд</p>

		<p>байна.</p> <p>4.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заажээ. Иймээс хуулийн төсөлд архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хор уршиг хэрэглээний эсрэг үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллагуудад архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр гэрээлэн гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төрлийг оновчтой тодорхойлж, төсвийн дэмжлэг үзүүлэх талаарх зохицуулалтыг нэмж тусгах.</p>	<p>зарчмын хувьд шийддэгдэх боломжтой.</p> <p>4.Саналд туссан асуудал хуулийн төслийн хүрээнд зарчмын хувьд шийддэгдэх боломжтой.</p>
3.	<p>Улсын Ерөнхий Прокурорын газар</p> <p>2020.10.29 7/5660</p>	<p>Танай 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 1-1/785 дугаартай албан бичгээр ирүүлсэн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдтэй танилцаад, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>Нэг. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлд:</p> <p>1.1 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт нийцүүлэн хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь/хэсгийн “...мэргэжлийн хяналтын байгууллагын саналыг үндэслэн...” гэснийг “...мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн...” гэж өөрчлөх.</p> <p>1.2 Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “...сэргээж” гэсний дараа “дуусгавар болгож,” гэж нэмэх.</p> <p>1.3 Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “...хүнсний...” гэсний дараа “болон мэргэжлийн хяналтын...” гэж нэмж, “...гишүүний” гэснийг “гишүүдийн” гэж өөрчлөх. Үндэслэл нь согтууруулах ундаа үйлдвэрлэх арга, ашиглах түүхий эд, үйлдвэрлэлийн байршил, хүчин чадал, техник технологи, боловсон хүчний хүчин чадал зэрэгт тавих стандарт, шаардлага нь мэргэжлийн хяналтын байгууллагын эрхлэх асуудалд хамаарч, хуулийн төсөлд зааснаар мөн биелэлтэнд нь хяналт тавихаар байна.</p> <p>1.4 Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь...” гэснийг “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь...” гэж өөрчлөх. Үндэслэл нь хуулийн</p>	<p>Саналыг тусгасан</p> <p>Дуусгавар болгох харилцааг хуулийн төслөөс хассан.</p> <p>Төрийн байгууллага хооронд тодорхой асуудлаар санал авах асуудал нээлттэй тул төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн.</p>

		<p>төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт зааснаар тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгохоор, мөн зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгох нь Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна.</p> <p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлүүд нь тус хуулийн төслийг дагаж боловсруулагдсан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зөрчлүүдтэй давхарджээ. Өөрөөр хэлбэл Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр зөрчилд тооцон, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслөөр тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх үндэслэл болгосон байгаа нь хуулиуд нэг мөр хэрэгжих боломжгүй нөхцөл байдлыг үүсгэхээр байна.</p> <p>Иймд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд заасан зөрчлөөс ялгаж, ойлгомжтой байдлаар томъёолох, эсхүл Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зарим төрлийн зөрчлийг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлээс үйлдлийн арга, үр дагавар, хор уршгаараа ялгамжтай байхаар хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна.</p> <p>1.5 Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн 9.1.4-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл нь тус хуулийн төслийн 10 дугаар зүйлийн дахь хэсгийн 10.2.3, 10.2.11, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн 9.1.3-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл нь тус хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн 10.2.7, 10.2.8-д заасан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлүүдтэй агуулгаараа ижил буюу зохицуулалт нь давхарджээ. Иймд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг хүчингүй болгох үндэслэлээс ялгамжтай, ойлгомжтой байдлаар томъёолох шаардлагатай байна.</p> <p>1.6 Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх талаар санал гаргах субъект, түүнийг шийдвэрлэх субъект, тэдгээрийн процесс ажиллагаа, түүний хугацаа, түдгэлзүүлсэн болон сэргээсэн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэх ажиллагаа, түүний хугацаатай холбоотой зохицуулалтыг нэмж тусгах. Үндэслэл нь хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь</p>	<p>Тусгай зөвшөөрлийг Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч мөн олгож, сунгаж буй тул саналыг аваагүй болно.</p> <p>Саналыг анхаарсан болно.</p>
--	--	---	--

	<p>хэсэгт зааснаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх үйл ажиллагаа нь тодорхой үр дагаваруудыг үүсгэхээр байна.</p> <p>1.7 Хуулийн төслийн дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэрийн биелэлт, хэрэгжилтэд хэн, хэрхэн хяналт тавихыг тодорхой болгож, хуулийн төсөлд нэмж тусгах.</p> <p>1.8 Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн 10.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн 19.1.1-ийн "...сүүлд..." гэснийг тус тус "...зөвшөөрөл олгосноос хойш..." гэж өөрчлөх.</p> <p>1.9 Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт "согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан;" гэсэн заалт нэмэх.</p> <p>1.10 Хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох, хүчингүй болгох шийдвэр, үйл ажиллагааны биелэлт, хэрэгжилтэнд хэн, хэрхэн хяналт тавихыг тодорхой болгож, хуулийн төсөлд нэмж тусгах.</p> <p>1.11 Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн "...тогтмол мэдээлэх..." гэснийг тодорхой болгож зохицуулах. Өөрөөр хэлбэл тогтмол гэдэгт ямар цаг хугацааг хамааруулах нь ойлгомжгүй байна.</p> <p>1.13 Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан "...энэ хуулийн 12.1-д заасан шаардлагыг биелүүлэх боломжгүй тохиолдол..." гэдэгт юуг ойлгох, ямар нөхцлийг хамааруулах нь тодорхой бус, ойлгомжгүй байна. Ялангуяа хуулийн төслийн 9, 10 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлээс өөр, ялгаатай ямар шалтгаан нөхцөл байхыг хуулийн төсөлд тодорхой тусгах.</p> <p>1.13.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах. Үндэслэл нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоох, үндэслэл, журмыг тусгайлсан журмаар зохицуулах шаардлагагүй бөгөөд энэ асуудлыг хуулийн төсөлд нэмж тусгах.</p> <p>1.14 Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт заасан "...үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх..." үндэслэлээр үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоох хугацааг, түүнчлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр</p>	<p>Саналыг хүлээн авч ажилласан болно.</p> <p>Хуулийн төсөл болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулсан болно.</p> <p>Хуулийн төслийн 40 дүгээр зүйлд согтууруулах ундаа үйлдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих этгээдийг заасан болно.</p> <p>Санал зарчмын хувьд туссан болно.</p>
--	--	---

	<p>зогсоосон хугацааг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд оруулж эсхүл хасч тооцох эсэхийг хуулийн төсөлд тодорхой болгож зохицуулах.</p> <p>1.15 Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Гадаад улсад экспортлохоос бусад согтууруулах ундааны шошго нь монгол хэл дээр байх бөгөөд гадаад улсад экспортлох тохиолдолд энэ зүйлийг мөрдөхгүй байж болно.” гэж өөрчлөх. Учир нь хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан шошгонд тавигдах шаардлага нь зайлшгүй тусгавал зохих ерөнхий мэдээлэл байх ба Монгол Улсад үйлдвэрлэгдсэн, экспортонд гаргах бүтээгдэхүүний хувьд тус мэдээллүүд тусгагдсан байвал зохино. Харин тэдгээрийг монгол хэл дээр бичих шаардлага тавихгүй байж болно гэж үзэж байна.</p> <p>1.16 Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн 14.1.2-ын “...урлаг...” гэснийг “...урлагийн...” гэж өөрчилж, “...сувиллын...” гэснийг хасах.</p> <p>1.17 Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “...зөвшөөрлийг...” гэсний дараа “харъяа мэргэжлийн хяналтын болон Цагдаагийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн...” гэж нэмэх. Үндэслэл нь тус байгууллагууд чиг үүргийн хүрээнд болон хуулийн төслийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасны дагуу хяналт тавихаар байна.</p> <p>1.18 Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “...нийтийн хоолноос бусад чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч...” гэснийг тодорхой болгох. Өөрөөр хэлбэл хуулийн төслийн дээрх заалт нь уул уурхай, хөдөө аж ахуй, соёл урлаг, оёдол гэх мэт бүх төрлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид хамаарахаар ойлгогдож байна.</p> <p>1.19 Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг бүхэлд нь хасч, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, түүнийг тогтоох үндэслэл, журмыг хуулийн төсөлд тодорхой тусгах. Өөрөөр хэлбэл тус хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шалтгаан, хуулийн төслийн гол үзэл баримтлал бүхий асуудлыг хуулийн төсөлд тусгалгүйгээр тусад нь журмаар зохицуулах шаардлагагүй гэж үзэж байна.</p> <p>1.20 Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн 19.1.10 дахь заалт нь мөн зүйлийн 19.1.7 дахь заалттай давхардсан байх тул хасах.</p> <p>1.21 Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.9 дэх заалтыг “хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн</p>	<p>Санал туссан болно.</p> <p>Хяналт тавих этгээдийг хуулийн төслийн 40 дүгээр зүйлд тодорхойлсон болно.</p> <p>Мэдээлэл хүргүүлэх хугацааг тогтоосон холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлэх үүргийг ерөнхий байдлаар тугасан болно.</p> <p>Саналыг тусгаагүй болно.</p> <p>Санал хэсэгчлэн туссан болно.</p> <p>Саналыг тусгаагүй болно. Монгол Улсад худалдахгүй</p>
--	--	---

		<p>хичээлийн болон дотуур байр, түүнээс 100 метрийн дотор;" гэж өөрчлөх.</p> <p>1.22 Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 23.1.8 дах заалтын "согтууруулах ундааг гар дээрээс, эсхүл..." гэснийг хасах. Үндэслэл нь хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 23.1.5 дах заалттай давхардсан байна.</p> <p>1.23 Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт "24.1.Ю.Онц байдал зарласан газар, хугацаанд;" гэсэн заалт нэмэх.</p> <p>1.24 Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн "...00-11 цагийн хооронд..." гэснийг "...00-8 цагийн хооронд..." гэж өөрчлөх.</p> <p>1.25 Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн "...ундны усаар үнэ төлбөргүй үйлчилнэ." гэснийг илүү тодорхой болгож зохицуулах. Өөрөөр хэлбэл үнэгүй үйлчлэх ундны усны чанар, стандарт, хэмжээ, савалгаа нь тодорхой бус байгаагаас хуулийн тус заалт хэрэгжих, түүнд эрх бүхий байгууллага, албан тушаалтан, үйлчлүүлэгч хяналт тавих боломжгүй байдлыг үүсгэхээр байна.</p> <p>1.26 Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсгийг бүхэлд нь хасч, нийтлэгээр тавигдах наад захын стандарт шаардлагыг тус хуулийн төсөлд нэмж тусгах.</p> <p>1.27 Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн "...эзэмшигч хариуцна." гэснийг "...эзэмшигчид хариуцуулж болно." гэж, хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн "...шаардсан этгээд хариуцна" гэснийг "...шаардсан этгээдэд хариуцуулж болно" гэж тус тус өөрчлөн найруулах. Үндэслэл нь бусдад гэм хор учруулсан этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн үр дагаврыг бүрэн арилгах, хариуцах үүрэгтэй. Харин бусдыг буруутай үйл ажиллагаа хийх, гэм хор учруулахад шууд хүргэсэн, нөлөөлсөн этгээдэд гэм хорыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээлгэж болох юм.</p> <p>1.28 Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн 30.1.3-т заасан жирэмсэн хүн согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон заалтын хэрэгжилтийг хангах, зөрчсөн тохиолдолд хэрхэх тухай зохицуулалт хуулийн төсөлд тусгагдаагүйгээс энэ нь хэрэгжих боломжгүй заалт болсон байх тул анхаарч, нягтлах.</p> <p>1.29 Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн 32.1.5 дахь заалт</p>	<p>согтууруулах ундааны шошгыг экспортлох улсын хууль тогтоомжоор шошгод тавигдах шаардлага нийцүүлэх нь зохимжтой.</p> <p>Найруулгыг анхаарсан болно.</p> <p>Саналыг авах шаардлагагүй гэж үзсэн болно.</p> <p>Саналыг зарчмын хувьд тусгасан болно.</p> <p>Саналыг зарчмын хувьд тусгасан болно.</p>
--	--	--	--

		<p>нь ойлгомжгүй, тодорхой бус байх тул найруулгыг дахин нягталж, өөрчлөх.</p> <p>1.30 Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн хориглосон заалтууд нь тус хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “Арван найм, түүнээс дээш хувийн этилийн спирт агуулсан согтууруулах ундааг сурталчлахыг хориглоно.” гэсэн заалттай агуулгаараа зөрчилдөж байна. Үндэслэл нь хуулийн төслийн 32 дугаар зүйлийн зохицуулалт нь тус хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.1-д заасан согтууруулах бүх төрлийн ундаанд хамаарахаар байгаа бол хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн зохицуулалт нь Арван найм, түүнээс доош хувийн этилийн спирт агуулсан согтууруулах ундаанд хамаарахгүй байхаар ойлгогдож байна. Иймд хоёрдмол агуулга, зохицуулалт үүсгэж буй хуулийн заалт хоорондын зөрчлийг арилгаж, өөрчлөх.</p> <p>1.31 Хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг “Согтууруулах ундааг сурталчилахад 25 нас хүрээгүй хүнийг оролцуулах, 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа хэрэглэхийг зааж сургахыг хориглоно.” гэж өөрчлөн найруулах.</p> <p>1.32 Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “...Согтуурч,... ” гэснийг “...Согтуурах, ...” гэж өөрчлөн, хүчин төгөлдөр хуулийн нэршилд нийцүүлэх.</p> <p>Хоёр. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд:</p> <p>2.1 Хуулийн төслийн 5 дугаар зүйлийг “2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу олгогдсон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн тоог батлах хүртэл хугацаагаар сунгана.” гэж өөрчлөн найруулах. Үндэслэл нь хугацаа дуусч байгаа тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар сунгах нь тус хуулийн төслийн 2, 3 дугаар зүйл бүрэн хэрэгжих боломжгүй, мөн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт 1 жилийн хугацаагаар хойшлох, хууль нэг мөр хэрэгжих боломжгүй байдлыг үүсгэнэ.</p> <p>Гурав. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:</p> <p>3.1 Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “35.2.3.11-22 цаг хүртэл...” гэснийг “35.2.3.14-04 цаг хүртэл...” гэж, “35.2.4.14-04 цаг хүртэл...” гэснийг “35.2.4.11-22 цаг</p>	<p>Саналыг авсан болно.</p> <p>Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>Саналыг авсан болно.</p> <p>Санал хуулийн төслийн 21 дүгээр зүйлд зарчмын хувьд туссан болно.</p> <p>Цагийн хязгаарлалтыг хассан болно.</p> <p>Хуулиар зохицуулах шаардлагагүй.</p>
--	--	---	---

		<p>хүртэл...” гэж тус тус өөрчлөх. Үндэслэл нь согтууруулах ундаагаар үйлчлэх хугацаа, тусгай зөвшөөрлийн нөхцөлтэй шууд хамааралтайгаар тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тооцож, тогтоох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл 22 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход хураах тэмдэгтийн хураамж нь шөнийн 04 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжаас бага байх нь зүйтэй юм.</p> <p>Дөрөв. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд:</p> <p>4.1 Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “14<sup>1</sup>.5.1.21 нас...” гэснийг “14<sup>1</sup>.5.1.25 нас...” гэж өөрчлөх. Үндэслэл нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт 25 нас хүрээгүй хүнийг согтууруулах ундаа сурталчлахад оролцуулахыг хориглохоор заасантай нийцүүлэх.</p> <p>4.2 Зар сурталчилгааны тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1</sup>.4 дэх хэсэгт “18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архийг үйлдвэрлэгч, борлуулагч аж ахуйн нэгж нь нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих зорилгоор ивээн тэтгэсэн, санхүүжүүлсэн, хандив өгсөн бол уг арга хэмжээг зохион байгуулж байгаа газарт тухайн бүтээгдэхүүнээ сурталчилсан ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад сурталчилгааны хэрэгслийг байрлуулж болно” гэж заажээ.</p> <p>Гэтэл Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн 32.1.1-д “аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах;”-ыг хориглохоор заасан.</p> <p>Мөн хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн 32.1.8-д “Согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, лого, барааны тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, кино, интернет, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргах;”, 32.1.10-т “...спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;”, 32.1.11-д “эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон</p>	<p>Саналыг аваагүй болно. Нийтлэг шаардлагыг хуулийн төслийн 26 дугаар зүйлд тусгасан болно.</p> <p>Саналыг тусгасан болно.</p> <p>Саналыг тусгаагүй болно. Хариуцлага хүлээлгэхээс өөрөөр зөвлөн туслах чиг үүргийнхээ хүрээнд согтууруулах ундааны хор хөнөөлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх боломжтой.</p> <p>Саналыг тусгасан болно.</p>
--	--	---	--



		<p>согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх;" зэргийг тус тус хориглоно гэж заасан.</p> <p>141.4 Иймд дээрх хуулийн төслийн зохицуулалтууд болон Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн Зар сурталчилгааны тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн дэх хэсгийг хүчингүй болгох.</p> <p>4.3 Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн 32.1.1-д заасан "...спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах,...", 32.1.8-д заасан "...согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, лого, барааны тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, ...болон бусад биед байдлаар гаргах;", 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан "Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулах таниулах талаар ...хэвлэл мэдээлэл, ... бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй." гэсэн зохицуулалтыг Зар сурталчилгааны тухай хуульд нэмж тусгах. Үндэслэл нь Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөлд тусгагдсан дээрх хориглолт, хязгаарлалтууд нь Зар сурталчилгааны тухай хуульд тусгагдаагүй байгаагаас хууль бүрэн хэрэгжих боломжгүй, зөрчилдөөнтэй байдлыг үүсгэхээр байна.</p> <p>Тав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд:</p> <p>5.1 Хуулийн төсөлд заасан "Донтох өвчний хор уршигтай тэмцэх үүргийн сан" нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн 19.3.5-д заасан "Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөл ээллөөс сэргийлэх" эрүүл мэндийг дэмжих сантай давхцаж байгаа эсэхийг нягтлах. Өөрөөр хэлбэл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийн 5.5.1-д заасан "Тусгай санг бүрдүүлэх эх үүсвэр тодорхой байх", 5.5.5-д заасан "бусад тусгай сангийн үйл ажиллагаатай давхардаагүй байх", 5.5.6-д заасан "холбогдох тооцоо, судалгаанд үндэслэсэн байх" зэрэг хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан үзэх.</p>	<p>Саналыг тусгасан болно.</p> <p>Саналыг авсан болно.</p> <p>Санал зарчмын хувьд туссан болно.</p>
--	--	--	---

		<p>5.2 Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2/21<sup>2</sup> дугаар зүйлийн 21<sup>2.5</sup> дахь хэсгийн найруулга ойлгомжгүй байх тул засч, өөрчлөх.</p> <p>Зургаа. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд:</p> <p>6.1 Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.11 дэх хэсгийн 15.11.2 дахь заалтыг “Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи болон согтууруулах ундаа үйлдвэрлэх” гэж өөрчлөн найруулсугай.” гэж өөрчлөх.</p> <p>6.2 Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг... аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгож...” гэж заасан. Иймд хуулийн төсөлд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх” гэсэн заалт нэмэх зохицуулалтыг нэмж тусгах.</p> <p>Долоо. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:</p> <p>7.1 Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлд өгсөн саналуудтай уялдуулан өөрчлөх шаардлагатай байна.</p> <p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага, тэдгээрийн үйл ажиллагаанд хориглосон, хязгаарласан заалтууд, мөн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, түр зогсоохтой холбоотой заалтуудыг ялгамжтай байдлаар, давхцал, зөрчилдөөн үүсгэхгүйгээр зохицуулах нь зүйтэй байна. Тухайлбал: Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавихархидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 10 дугаар зүйлийн 10.2, 18 дугаар зүйлийн 18.2, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлүүд нь Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчлүүдтэй давхардаж</p>	Саналыг авч 32.1.1
--	--	---	--------------------

		<p>байна.</p> <p>Мөн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлүүдэд заагдсан ноцтой зөрчил, үр дагавар бүхий үйлдлүүдийг зөрчилд тооцоогүй байна.</p> <p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэгт "...тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, худалдах, хариу төлбөртэйгээр ашиглуулах болон хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчлөхийг хориглоно." гэж заасан байхад Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, мөн зүйлийн 5 дахь хэсэгт "тусгай зөвшөөрлийг хууль бусаар бусдад шилжүүлсэн" гэсэн хуульд байхгүй шинжийг нэмсэн байна.</p> <p>Найм. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:</p> <p>Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зөрчлүүдийг дахин нягталж, өөрчлөлт оруулахтай холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг өөрчлөх эсэхийг шийдвэрлэх.</p>	
4.	<p>Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</p> <p>2020.10.06 ЗГ-2/751</p>	<p>1.Хуулийн төслийн 1-5 дугаар бүлэгт Согтууруулах ундааны үйлдвэрлэл, экспорт, импорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээтэй холбоотой харилцааг, 6, 7 дугаар бүлэгт Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавихтай холбоотой харилцааг тус тус зохицуулахаар тусгаснаас үзвэл Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих болон Архидан согтуурахтай тэмцэх асуудал нь хоёр өөр харилцаа гэж ойлгогдохоор байх тул хуулийн төслийн нэрийг Согтууруулах ундааны эрх зүйн зохицуулалт, түүнд тавих хяналтын тухай гэж өөрчлөн, Архидан согтуурахтай тэмцэх асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж буй Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд зохих өөрчлөлт оруулах замаар зохицуулж, уг хуульд Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай зэрэг хуулийг нэгтгэх боломжтой эсэхийг нягтлан үзэх;</p>	<p>1.Саналыг анхаарсан бөгөөд хуулийн төслийг тусгаарлах шаардлагагүй гэж үзсэн болно.</p>

		<p>2.Төслийн 16.8-ын "... төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Засгийн газрын гишүүд" гэж өөрчлөх;</p> <p>3.Төслийн 20 дугаар зүйлийн "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх түр зөвшөөрөл олгох" гэсэн зохицуулалт оруулах болсон үндэслэл, шаардлагыг дахин нягталж үзэх, түүнчлэн 20.1-д "Олон нийтийг хамарсан хурим найр, ..." гэсэн нэр томъёо ойлгомжгүй байгааг анхаарах;</p> <p>4.Төслийн 22.1.5-ын "... түүний ойр орчим" гэснийг хэдэн метр, ямар орон зай, хэмжээгээр тооцож тодорхойлохыг анхаарч үзэх;</p> <p>5.Төслийн 23.1.9 дэх заалт "Согтуурах, мансуурах донтой этгээдээр бүртгэгдсэн хүнд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх" гэж болон үүнтэй холбоотойгоор 37.3 дахь хэсэг "Согтуурах, мансуурах донтой этгээдийн нэгдсэн бүртгэлийг холбогдох байгууллага хөтөлж, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад хүргүүлнэ" гэсэн зохицуулалт тус тус нэмэх боломжтой эсэхийг анхаарч үзэх;</p> <p>6. Төслийн 26.4-т "... ундны усаар үнэ төлбөргүй үйлчилнэ" гэсэн нь амьдрал дээр хэрэгжих боломжтой эсэхийг анхаарч үзэх;</p> <p>7.Төслийн 30.3-т бусдад учруулсан гэм хорыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардсан этгээд хариуцна" гэснийг сайтар нягтлан үзэж, Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах;</p> <p>8.Төслийн 38.4-ийн "... төрийн бодлогоор дэмжинэ" гэснийг төрийн бодлогоор дэмжиж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлнэ" гэж өөрчлөн найруулах зэрэг болно.</p>	<p>2.Саналыг анхаарсан болно.</p> <p>3.Саналыг авч "хурим, найр" гэснийг хассан. Олон нийтийн зарим арга хэмжээнд хатуулаг багатай этилийн спирт агуулсан согтууруулах ундаагаар хариуцлагатай үйлчлэх хэрэгцээ шаардлага үүсдэг тул түр зөвшөөрлийг зохицуулалтыг оруулсан болно.</p> <p>4.Саналыг анхаарсан болно.</p> <p>5.Саналыг анхаарсан болно.</p> <p>6.Хэрэгжих боломжтой гэж үзэв.</p> <p>7.Иргэний хуулийн 497.3.Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ". гэж заасан.</p> <p>8.Саналыг анхаарсан болно.</p>
--	--	--	--

5.	Сангийн яам 2020.10.05 6/6439	<p>1.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсгийн дагуу “согтууруулах ундаа” гэдгийг шинэчлэн тодорхойлсон байна. Иймд Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан онцгой албан ногдох согтууруулах ундааны нэр томъёог шинэчилсэн тодорхойлолттой уялдуулан өөрчлөх шаардлагатай байна;</p> <p>2.Хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт “согтууруулах ундаа нь онцгой албан татварын тэмдэгтэй байх бөгөөд онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалтуудаар “онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх”-ийг тус тус хориглож, зөрчсөн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоор тус тус заажээ. Хуулийн төслийн энэхүү зохицуулалт нь архинаас бусад согтууруулах ундаа буюу этилийн спиртийн агууламж багатай шар айрагт мөн адил онцгой албан татварын тэмдэг хэрэглэх шаардлагыг бий болгох ба Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна. Онцгой албан татварын тухай хуулийн дагуу Монгол Улсад үйлдвэрлэсэн болон импортолсон бүх төрлийн согтууруулах ундаанд онцгой албан татвар ногдох боловч түүний тэмдгийг этилийн спиртийн агууламж багатай бүх төрлийн согтууруулах ундаанд хэрэглэх нь зардал өндөртэй болохоос гадна түүний хог хаягдал нь байгаль орчинд ээлгүй байх тул 18 хүртэл хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундаа онцгой албан татварын тэмдэггүй байж болох өөрчлөлтийг хуулийн төслийн холбогдох хэсэгт оруулах;</p> <p>3.Хуулийн төслийг дагалдан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр шинээр байгуулах “Донтох өвчний хор уршигтай тэмцэх үүргийн сан”-гийн чиг үүргийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх боломжтой байх тул Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь хасаж, тус чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийн ерөнхийлөн захирагчийг хуулийн төсөлд тодорхой тусгах;</p> <p>4.Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалтад согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл нь “14-04 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх” гэж</p>	<p>1.Саналыг аваагүй. Согтууруулах ундааг нэр томъёоны хувьд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд тодорхойлсон байдаг тул хуулийн шинэчилсэн найруулга болох Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлд тодорхойлолт оруулсан болно.</p> <p>2.Саналыг авч Онцгой албан татварын тэмдэгтийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 320 дугаар тушаалаар батлагдсан Онцгой албан татварын тэмдэг захиалах, хэвлүүлэх, татварын албадад хүргүүлэх, хадгалах, бүртгэх, аж ахуйн нэгжид олгох журамд заасны дагуу архи, дарс онцгой албан татварын тэмдэгтэй байхаар тусгав.</p> <p>3.Саналыг аваагүй бөгөөд Архидан согтуурах болон донтох өвчний хор уршигтай тэмцэх сан байгуулах хэрэгцээ, шаардлага байгаа болно.</p>
----	-------------------------------------	--	---

	<p>заасан боловч 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол 00-11 цагийн хооронд согтууруулах ундаа худалдахыг хориглоно” гэж заасан нь ойлгомжгүй байна. Дээр заасан тусгай зөвшөөрлийн дагуу согтууруулах ундаагаар үйлчлэх нь согтууруулах ундаа худалдсан гэж тооцогдохгүй гэсэн ойлголтыг бий болгохоор байна. Мөн нэгэнт согтууруулах ундаа худалдах, түүгээр ажиллах тусгай зөвшөөрөлтэй этгээдийн ажиллах цагийг хуульд тусгайлан заасан тул согтууруулах ундаа худалдах цагийг тусгайлан зохицуулах шаардлагагүй байж болох юм. Учир нь хуулиар согтууруулах ундаа худалдах цагийг хязгаарлах тусам албан ёсны зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар худалдаалах, чанар, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн зах зээлд бий болох эрсдэлтэйг анхаарах;</p> <p>5.Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь заалтын "гэрийн" гэснийг хасах, 23.1.8 дахь заалтын “дууссан” гэсний дараа түдгэлзүүлсэн” гэж нэмэх;</p> <p>6.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.9 дэх хэсгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн санал авах өдөр, түүний өмнөх болон дараагийн өдөр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож байгаа тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 70.1.1 дэх заалт, Сонгуулийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1.1 дэх заалтыг тус тус хүчингүй болгох хуулийн төсөл боловсруулах;</p> <p>7.Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийн “28.1-д” гэснийг “28.2-т” гэж, “худалдах,” гэснийг “худалдахгүй,” гэж тус тус өөрчлөх;</p> <p>8. Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “21 насанд хүрээгүй, эсхүл согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсний улмаас бусдад учруулсан гэм хорыг согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна” гэж заасан нь ерөнхий байна. Учир нь хуулийн төсөлд согтууруулах үндаа хэтрүүлэн хэрэглэж байгаа үйлчлүүлэгчид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхээс татгалзах эрх болон үүргийг зааж өгөөгүй тул үйлчлүүлэгч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэснээс учрах гэм хорыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хүлээх</p>	<p>4.Саналыг тусгасан.</p> <p>5.Саналыг тусгасан.</p> <p>6.Саналыг авч эдгээр хуульд заасан “санал авах өдрийг” хассан.</p> <p>7.Саналыг тусгасан.</p> <p>8.Саналыг тусгасан. Учирсан гэм хорыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцаж болохоор тусгасан.</p>
--	---	---

	<p>үндэслэлгүй юм. Иймд хуулийн 28 дугаар зүйлд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж байна гэж үзэх үндэслэл байвал тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний ажилтан согтууруулах ундаа худалдахаас татгалзах эрхтэй, мөн үүрэгтэй байх зохицуулалтыг нэмж оруулах, хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу хариуцлага хүлээх этгээд нь хуульд зааснаар баримт бичиг шалгах үүргээ хэрэгжүүлээгүй, согтууруулах ундаа илтэд хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчид согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч байх өөрчлөлтийг оруулах;</p> <p>9.Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь заалтын “ундааг” гэсний дараа “үйлчлүүлэгчид” гэж, 32.1.7 дахь заалтын “согтууруулах ундаагаар” гэсний өмнө “аж ахуй нэгж, байгууллага” гэж тус тус нэмэх, 32.1.9 дэх заалтын “согтууруулах ундааны нэрээр хуулийн этгээдийг нэрлэх, эсхүл” гэснийг хасах;</p> <p>10.Хуулийн төслийн 32.1.8 дахь заалт нь ерөнхий зохицуулалт байх ба хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, кино театраар үзүүлэх кино, дүрс бичлэг зэрэгт согтууруулах ундааны дүрс, зураг орсон тохиолдолд бүрсийлгэх эсэх талаар нарийвчилсан журмыг хуулийн төсөлд тусгах;</p> <p>11.Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1.10 дахь заалт нь аж ахуйн нэгж, байгууллагаас нийгмийн хариуцлагатай байх, тодорхой хандив, тусламж тэтгэлэг үзүүлэх эрхийг хэтэрхий хязгаарласан байх тул тус заалтын “арга хэмжээнд” гэсний дараа “согтууруулах ундаа сурталчлах зорилгоор” гэж нэмэх;</p> <p>12.Дээрх саналын дагуу хуулийн төслийн 32.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах бол хуулийн төслийг дагалдах Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтийг тусгах;</p> <p>13.Хуулийн төслийн нэр нь “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай” хууль бөгөөд түүний 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих журмыг Засгийн газар батална” гэсэн нь Засгийн газраас дахин энэхүү хуулиар зохицуулсан асуудлын талаар журам гаргах мэт ойлголтыг бий болгож байна. Иймд хуулийн төслийн тус хэсгийг хасах;</p> <p>14.Хуулийн төслийн 34 дүгээр зүйл нь Зар сурталчилгааны тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр</p>	<p>9.Найруулгын саналыг анхаарсан. Ажлын хэсгийн хуралдаанаар хуулийн этгээдийг согтууруулах ундааны нэрээр нэрлэхийг хориглох заалтыг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн болно.</p> <p>10.Саналыг аваагүй.</p> <p>11.Саналыг тусгасан.</p> <p>12.Саналыг анхаарсан боно.</p> <p>13.Саналыг тусгасан.</p>
--	--	--

		<p>зүйлийн зохицуулалттай давхардаж байх тул согтууруулах ундааг сурталчлах харилцааг хуулиар зохицуулна гэж ерөнхий тусгах;</p> <p>15.Хуулийн төслийг дагалдан боловсруулсан хуулийн төслөөр Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлтээр оруулах 14<sup>1.5.1</sup> дэх заалтын “21 нас” гэснийг “25 нас” гэж өөрчлөх, Зар сурталчилгааны тухай хуулийн 141.4 дэх хэсэг нь хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1.10 дахь хэсэгтэй зөрчилдөж байх тул тус хэсгийг хүчингүй болгох зохицуулалтыг дагалдах хуулийн төсөлд тусгах;</p> <p>16.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг нягтлах;</p> <p>17.Хуулийн төслийн 41 дүгээр зүйлд согтууруулах ундаа хууль бусаар үйлдвэрлэсэн, улсын хилээр нэвтрүүлсэн, борлуулсан зөрчлийн талаарх мэдээллийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу төлбөртэй авч болохоор заасан нь бие даасан хуулийн зохицуулалттай давхардсан байх тул тус 41 дүгээр зүйлийг хуулийн төслөөс хасах;</p> <p>18.Хуулийн төслийг дагалдан боловсруулсан хуулийн төслөөр нэмэлтээр оруулах Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “хоёр зуун мянган төгрөгөөр” гэснийг “хоёр зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр” гэж өөрчлөх.</p>	<p>14.Саналыг тусгасан болно.</p> <p>15.Саналыг тусгасан болно.</p> <p>16.Саналыг анхаарсан болно.</p> <p>17. Саналыг анхаарсан болно.</p> <p>18.Саналыг тусгасан болно.</p>
6.	Гадаад харилцааны яам 2020.09.18 08/4158	Хуулийн төслийг дэмжиж байна.	Хуулийн төслийг дэмжсэн.
		<p>Хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1.Төслийн 3.1.2 дахь заалтад “...эргэлт” гэснийг “сүлжээ” гэж өөрчлөх /Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.6 дахь заалтад “хүнсний сүлжээ гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх,баяжуулах,дахин боловсруулах,савлах,тээвэрлэх,</p>	1.Саналыг аваагүй болно.



<p>7.</p>	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</p> <p>2020.10.01 01/3424</p>	<p>хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг” гэж тодорхойлсон/;</p> <p>2.Мөн төслийн 3 дугаар зүйлийн Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод “3.1.3. “хатуулаг” гэж “Спиртийн уусмалд агуулагдах этилийн спиртийн хэмжээг эзлэхүүний хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг” гэж нэмэх,</p> <p>3.Төслийн 5.1 дэх хэсгийн “...дүгнэлтийг” гэсний өмнө болон 5.3 дахь хэсгийн “...санал” гэсний дараа “...улсын байцаагчийн” гэж тус тус нэмэх,</p> <p>4.Төслийн 5.2 дахь хэсгийн “...мэргэжлийн хяналтын байгууллагын” гэсний дараа “...улсын байцаагчийн дүгнэлт...” гэж нэмэх;</p> <p>5.Төслийн 5.5 дахь хэсгийн “...үйлдвэрлэх арга...” гэснийг хасах;</p> <p>6.Одоогийн нөхцөлд тусгай зөвшөөрлийг компанийн нэр дээр олгодог бөгөөд компанийн захирлын нэрийг өөрчлөн бусдад шилжүүлэх боломжтой байдаг тул төслийн 5.6 дахь хэсгийн “...бусдад шилжүүлэхийг хориглох” гэснийг тодорхой болгох,</p> <p>7.Төслийн 5.7 дахь хэсгийн “...хүнсний” гэсний дараа “санхүүгийн” гэж, “...байгууллага” гэсний дараа “хамтран” гэж тус тус нэмэх;</p> <p>8.Төслийн 7.1.1 дэх заалтын “...хэрэгсэлтэй” гэснийг “хэрэгсэл, технологийн заавартай” гэж өөрчлөх,</p> <p>9.Төслийн 7.1.3 дахь заалтад “үйлдвэрлэлийн үе шат бүрт дотоод хяналтыг хэрэгжүүлж, түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж ажиллах” гэж нэмэх;</p> <p>10.Төслийн 8.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэснийг “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж өөрчлөх,</p>	<p>2.Саналыг тусгасан болно.</p> <p>3.Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>4.Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>5.Саналыг аваагүй.</p> <p>6.Хуулийн төслийн 5.8-д тусгай зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлэх, ашиглуулахыг хориглохоор тусгасан болно.</p> <p>7.Саналыг аваагүй. Үйлдвэрлэлийн хүчин чадал тооцоолоход сангийн яамны оролцоо шаардлагагүй гэж үзэв.</p> <p>8.Саналыг тусгасан болно.</p> <p>9.Саналыг тусгасан болно.</p> <p>10.Тусгай зөвшөөрлийг бусад этгээд олгож байх тул саналыг тусгаагүй.</p>
-----------	---	---	---

		<p>11.Төслийн 9.1.3 дахь заалтад “...боломжгүй болсон” гэснийг тодруулах,</p> <p>12.Төслийн 11.4 дэх хэсэгт оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хяналт тавих талаар тусгах,</p> <p>13.Төслийн 11 дүгээр зүйлд “Чанарын алба, нэгж, ажилтан нь бүтээгдэхүүний цуврал бүрийг дотоодын хяналтын лабораторийн сорилтын үр дүнг үндэслэн чанарын гэрчилгээ үйлдэн баталгаажуулж, худалдаа үйлчилгээнд гаргадаг байх” гэж мөн “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох, тоног төхөөрөмж болон ажлын байр өөрчлөгдөх бүрт мэдээллийг хяналтын байгууллага болон тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэнэ.”, “Үйлдвэрийн байр, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл, үйлдвэрийн орчинд хортон, шавж, мэрэгчгүйтгэлд болон үйлдвэрийн ажилтан, албан хаагчдын эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуйн байдалд тавих шаардлагыг хангасан байна.” гэсэн агуулаг бүхий заалт нэмэх;</p> <p>14.Төслийн 12.1 дэх хэсгийн “...тодорхой хувиас...” гэснийг тодруулах,</p> <p>15.Төслийн 13.1.4 дэх заалтыг хасах,</p> <p>16.Төслийн 13.2 дахь хэсгийн "...шошго нь монгол хэл дээр байх..." гэсэн нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 12.6,-д “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна” гэж заасантай нийцэхгүй байна.</p> <p>17.Төслийн 15.1 дэх хэсгийн “гадаад улсаас...” гэснийг хасах,</p> <p>18.Төслийн 15.1 дэх хэсэг болон 15.6 дахь хэсгийн “...хүнсний...” гэснийг “худалдааны” гэж өөрчлөх;</p> <p>19.Төслийн 15.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 15.1-д заасны дагуу...” гэснийг хасах;</p>	<p>11.Саналыг тусгаагүй. Хуулийн төслийн 12.4-т журам батлахаар заасан болно.</p> <p>12.Саналыг авч хяналт тавих этгээдэд нэмсэн болно.</p> <p>13.Эдгээр нь холбогдох хууль, стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулж байна.</p> <p>14.Үйлдвэр бүрт бүтээгдэхүүн үйлдвэрлэх хувь хүчин чадал харилцан адилгүй бөгөөд тогтоох этгээдийг төслийн 5.9-д тодорхойлсон.</p> <p>15.Саналыг аваагүй болно.</p> <p>16.Саналыг аваагүй болно.</p> <p>17. Санал туссан болно.</p> <p>18.Саналыг аваагүй болно.</p>
--	--	---	--

		<p>20.Төслийн 15.5 дахь хэсэгт "...журмыг..." гэсний дараа "худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн" гэж нэмэх;</p> <p>21.Мөн төсөлд согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч согтууруулах ундаа /бөөнөөр болон жижиглэн/ худалдах тусгай зөвшөөрөл авах эсэх талаар тусгах;</p> <p>22.Төслийн 3 дугаар бүлэгт дор дурдсан агуулаг бүхий "Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага" гэсэн зүйл нэмэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн инженер-технологич, согтууруулах ундааны хими-технологич, химийн технологич, хүнсний үйлдвэрлэлийн технологич, эрүүл ахуйч мэргэжлийн хүний нөөцтэй байх,</li> <li>- Хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч нь урьд өмнө Согтууруулах ундааны нийлүүлэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, тогтоомж зөрчиж, шийтгүүлж байгаагүй байх;</li> <li>- Сүүлийн 3 жилийн хугацаанд татварын ямар нэгэн зөрчил, хугацаа хэтэрсэн татварын болон бусад өр, төлбөргүй байх;</li> <li>- Хуулийн этгээд, эсхүл түүний удирдах албан тушаалтан нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх агуулах, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх; Бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авах дотоод журам, зааврыг баталж, татан авах үйл ажиллагааг хариуцсан ажилтан, албан тушаалтныг томилон ажиллуулах, дотоод хяналтын журмыг батлан, үйлдвэрлэлийн үе шат бүрт дотоод хяналтыг хэрэгжүүлж, түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцан ажиллах;</li> <li>- Чанарын алба, нэгж, ажилтан нь бүтээгдэхүүний цуврал бүрийг дотоодын хяналтын лабораторийн сорилтын үр дүнг үндэслэн чанарын гэрчилгээ үйлдэн баталгаажуулж, худалдаа үйлчилгээнд гаргадаг байх;</li> <li>- Худалдаа үйлчилгээнд техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан согтууруулах ундаа нийлүүлдэг байх,</li> </ul>	<p>21. төслийн 15.5 дахь хэсэгт импортлох журмыг Засгийн газар батлахаар тусгасан болно.</p> <p>22.согтууруулах ундаа импортлохтой холбогдсог үйл ажиллагааг төслийн 15 дугаар зүйлд зохицуулсан%</p>
--	--	--	---

		<p>- Төслийн 16.2 дахь хэсгийн "...журмыг" гэсний дараа "худалдааны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний саналыг үндэслэн" гэж нэмэх;</p> <p>23. Төслийн 17.3 дахь хэсэгт "...нийтийн хоол..." гэснийг "хоол үйлдвэрлэл үйлчилгээ" гэсэн нэр томъёо хэрэглэх,</p> <p>24.Төслийн 22.1.9 дэх заалтад "...100 метрийн дотор..." гэснийг Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд сургуулийн орчинг 150 метр гэж заасантай нийцүүлэх;</p> <p>25.Төслийн 27.3 дахь хэсгийг "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтыг аймаг, нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан нэгж зохион байгуулж, боловсролын асуудал хариуцсан байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд гүйцэтгэх бөгөөд төлбөрийн жишгийг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно." гэж өөрчлөн найруулах;</p> <p>26.Төслийн 39.2 дахь хэсэгт "...журмыг" гэсний дараа "Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн" гэж нэмэх;</p> <p>27.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.7 дахь заалтын "...15.10.14" гэсний өмнө "15.10.12" гэж нэмэх " гэсэн агуулгатай зүйл нэмэх саналтай байна</p>	<p>23.Саналыг тусгасан болно.</p> <p>24.Саналыг анхаарсан болно.</p> <p>25.Саналыг анхаарсан болно.</p> <p>26.Заалт хасагдсан болно.</p> <p>27.Согтууруулах ундаа импортлоход орон нутгийн буюу Засаг даргын саналыг авах шаардлага ойлгомжгүй байна.</p>
8.	Хөдөлмөр, нийгмийн	<p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналтай байна.</p> <p>1.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь хэсгийн "... татварын ..." гэсний дараа " ..., нийгмийн даатгалын шимтгэлийн.. " гэж нэмэх;</p> <p>2. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тусгай зөвшөөрлийн хугацааг хэдэн удаа сунгах зохицуулалтыг нэмэх;</p>	<p>1.Саналыг аваагүй болно.</p> <p>2.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тул тусгай</p>

	<p>хамгааллын яам</p> <p>2020.09.25 1/2754</p>	<p>3. Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “... тусгай зөвшөөрлийг...” гэсний дараа “... татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй, хууль тогтоомжид заасан шаардлага хангасан...” гэж нэмэх;</p> <p>4. Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “энэ хуулийн 23.1.1, 23.1.2 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.2, 40.3.4 дэх хэсэгт заасан байгууллага, албан тушаалтны саналыг үндэслэн” согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зохицуулалтыг нэмэх;</p> <p>5.Хуулийн төслийн 23.1 дэх хэсэгт “23.1.9. согтууруулах ундааг хүнд зээлээр болон дараа төлөх хэлбэрээр худалдан борлуулахыг хориглох бөгөөд энэ заалтыг зөрчсөн тохиолдолд согтууруулах ундааны үнийг буцаан шаардах эрхгүй.” гэсэн заалтыг нэмэх;</p> <p>6.Хүүхдийн мөнгийг сар бүрийн 21-ний өдөр олгодог тул хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “... эхний...” гэсний дараа “...21...” гэж нэмэх;</p> <p>7.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “ахмадын өдөр, 10 дугаар сарын 01”, “монгол цэргийн өдөр. 3 дугаар сарын 18” гэж нэмэх;</p> <p>8.Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “0-8 хүртэлх насны хүүхэд дагуулж яваа” хүнийг нэмэх;</p> <p>9.Хуулийн төслийн 38 дугаар зүйлд “38.5. Энэ хуулийн 6.1.1 дэх заалтад заасан баримт бичигт архидан согтуурахтай тэмцэх олон нийтийн үүсгэл санаачлагыг дэмжих асуудлыг тусган хэрэгжүүлнэ.” гэж нэмэх;</p> <p>10.Хуулийн төслийн 40 дүгээр зүйлийн 40.3.4 дэх хэсгийн “... улсын байцаагч;” гэсний дараа “... хүүхдийн эрхийн улсын байцаагч” гэж нэмэх;</p> <p>11. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд...” гэснийг “Тусгай зөвшөөрөл сунгах эрх бүхий этгээд...” гэж өөрчлөх;</p>	<p>зөвшөөрлийг сунгах тоо хэмжээ тогтоох боломжгүй.</p> <p>3.Саналыг аваагүй болно.</p> <p>4.Саналыг анхаарсан болно.</p> <p>5.Саналыг анхаарсан болно. төслийн 32.1.6-д зээлээр худалдах, үйлчлэхийг хориглосон.</p> <p>6.Архигүй өдрийн тоог нэмэгдүүлэх нь хууль бус архины худалдааг нэмэгдүүлдэг тул саналыг аваагүй болно.</p> <p>7. Дээрхтэй адил.</p> <p>8.Саналыг анхаарсан болно.</p> <p>9.Санал зарчмын хувьд туссан. Хуулийн төсөлд согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс тодорхой хувиар төлүүлсэн хөрөнгийг архидан согтуурахтай тэмцэх ажиллагаанд зарцуулах зохицуулалт туссан.</p>
--	--	---	---

		<p>12.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтыг “... өмчийн хэлбэр үл харгалзан хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургалтын байгууллага, тэдгээрийн дотуур байр, хүүхдийн хөгжлийн болон хамгааллын төв, эмнэлэг,сувилал, соёл урлаг, сувиллын газар тэдгээрийн эзэмшил, ашиглалтад байгаа бүх төрлийн байгууламж” гэж өөрчлөн найруулах;</p> <p>13.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтын “нийтийн зориулалттай ...” гэснийг “нийтийн болон амины ...” гэж өөрчлөн найруулах;</p> <p>14.Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1.9 дэх заалт “ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, ...” гэснийг “Өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны сургуулийн хичээлийн болон дотуур байр, ...” гэж өөрчлөн найруулах;</p> <p>15.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтыг өөрчлөн найруулсантай холбоотой хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтыг хасах;</p> <p>16.Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсгийг хасах;</p> <p>17.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг хаана гаргахыг тодорхой тусгах зэрэг болно.</p>	<p>10. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийг нэмсэн болно.</p> <p>11.Санал туссан болно.</p> <p>12.Саналыг анхаарсан болно.</p> <p>14.Өмчийн хэлбэр заагаагүй тул бүгд хамаарна.</p> <p>17.Сунгах эрх бүхий этгээдийн хуулийн төслийн 5.3-т заасан.</p>
9.	Эрүүл мэндийн яам	<p>Санал авахаар ирүүлсэн “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг өгч байна. Үүнд:</p> <p><b>НЭГ. Хуулийн төслийн Нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт-д дараах хэсэг, заалтыг өөрчлөн найруулах болон нэмэлтээр оруулах саналтай.</b></p> <p>1/ “согтууруулах ундаа” гэж хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт,</p>	<p>1.Саналыг аваагүй.</p> <p>2.Саналыг аваагүй болно.</p>

	<p>2020.10.02 1a/4150</p>	<p>бүх төрлийн архи, 1.2 хувиас дээш этилийн спирт агуулсан дарс, шар айраг, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архийг; гэж өөрчлөх</p> <p>2/ “согтох” гэж согтууруулах ундааг ууснаас хүний ухаан балайрах болон амьсгал дахь спиртийн агууламж 0.20 промилль (%о), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5 промилль (%о) ба түүнээс дээш болж нэмэгдэх байдлыг; гэж нэмэх.</p> <p><b>ХОЁР. Хуулийн төслийн Нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээд дараах заалтыг нэмэлтээр оруулах саналтай.</b></p> <p>3/ 4.1.5.найрлага дахь этилийн спиртийн агууламж нь 1.2 хувь хүрэхгүй хүнсний бүтээгдэхүүний зохицуулалт.”</p> <p><b>4/ ГУРАВ. Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг. Согтууруулах ундаы үйлдвэрлэл-</b> согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, түүнийг авахад бүрдүүлэх баримт бичиг, эзэмшигчдэд тавигдах шаардлага, түүний хугацаа, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгох, хүчингүй болгох тухай зохицуулалтыг тусгасан зүйл, хэсэг заалтыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлдвэрлэх хэмжээ, согтууруулах ундааны шошго, савалгаанд тавигдах шаардлага, үйлдвэрлэл эрхлэхийг хориглох газар зэргийг зохицуулсан зүйл, хэсэг, заалтын өмнө оруулсан байрлалтайгаар боловсруулжээ.</p> <p>Энэ хоёр байрыг солих. Учир нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлагад үйлдвэрлэлтэй холбоотой хэсэг, заалтыг ишлэн дурдах болон эдгээрийг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай зэрэг зохицуулалтыг холбоход дөхөмтэй юм. Энэ санааг мөн согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал дээр давтах. Үйлдвэрлэл үйлчилгээнд тавигдах шаардлага, хориглох зүйл, заалтыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалт оруулах.</p> <p><b>ДӨРӨВ. Хуулийн төслийн 6 дугаар зүйлд доорх агуулгатай хэсэг нэмэх</b></p> <p>5/ 6.1.8.Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас согтууруулах ундааны үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай эсэх тухай болон</p>	<p>3. 2 хувийн этилийн спирт агуулсан бүтээгдэхүүнийг согтууруулах ундаанд тооцож байх тул хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй тул саналыг тусгах шаардлагагүй гэж үзсэн.</p> <p>4.Саналыг анхаарсан болно.</p> <p>5.Үйлдвэрлэл хөгжүүлэх асуудал хуулийн төсөлд тусгагдаагүй тул энэ талаар санал авах шаардлагагүй гэж үзсэн.</p>
--	-------------------------------	--	---

	<p>хүн амын согтууруулах ундааны хэрэглээний байдлын талаарх санал, дүгнэлт гэж нэмэх.</p> <p><b>ТАВ. Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг. Согтууруулах ундааны үйлдвэрлэл-д</b> хамаарах зүйлүүдэд дараах утга агуулгатай хэсэг, заалтыг өөрчлөн найруулах болон нэмэх саналтай байна.</p> <p>6/Согтууруулах ундааны шил, савыг эргүүлэн хэрэглээнд оруулах, дахин ашиглах тогтолцоо, дамжлагыг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлнэ гэж нэмэх.</p> <p>7/Гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд арван найм хүртэл хувийн этилийн спирт бүхий согтууруулах ундааг 1.5 литрээс их, арван наймаас гучин тав хүртэл хувийн этилийн спирт бүхий согтууруулах ундааг 0.33 литрээс бага, 0.5 литрээс их хэмжээгээр, гучин таваас дээш хувийн этилийн спирт бүхий согтууруулах ундааг 0.33 литрээс бага, 0.75 литрээс их хэмжээгээр савлахыг хориглоно гэж өөрчлөн найруулах.</p> <p>8/ Аль ч төрлийн согтууруулах ундаанд хуванцар савалгааг хориглоно гэж нэмэх.</p> <p><b>9/ ЗУРГАА. Хуулийн төслийн 17.дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн төрөл-д 17.1 дэх хэсгийг дараах утга агуулгатайгаар өөрчлөн найруулах</b></p> <p>17.1. Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна.</p> <p>17.1.1. арван найм хүртэл хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг худалдах,</p> <p>17.1.2. арван наймаас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг худалдах гэж өөрчлөх</p> <p><b>10/ ДОЛОО. Хуулийн төслийн 17.дугаар зүйлд 17.2 дахь хэсэгт дараах утга агуулгатай өөрчлөлтийг хийх</b></p> <p>Хуулийн төслийн 17.2-д заасан зохицуулалтыг хуулийн төслийн 25</p>	<p>6.Шил, савыг эргүүлэн татах шаардлагыг 13.9-д тусгасан болно.</p> <p>7.Зарим төрлийн согтууруулах ундааны савалгааны хэмжээ заасан зохицуулалт хуулийн төслийн 13 дугаар зүйлд туссан.</p> <p>8. MNS 0179:2016 стандартад “Цагаан болон өвөрмөц архи, техникийн ерөнхий шаардлага” стандартаар архийг хуванцар саванд савлахыг зөвшөөрсөн байдаг.</p> <p>9.Саналыг анхаарсан болно.</p> <p>10.Санал зарчмын хувьд хуулийн төслийн 17 дугаар зүйлд туссан болно.</p>
--	---	--



		<p>дугаар зүйл рүү багтааж оруулах, тусгай зөвшөөрөл болгох шаардлагагүй.</p> <p>Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Энэ хуулийн 17.2.1-д заасан тусгай зөвшөөрлийг нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд...” олгоно гэжээ. Нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд</p> <p>Ресторан, кафе, баар, цайны газар, түргэн хоолны газар, хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн худалдах дэлгүүр /кулинари/, буфет зэрэг ордог тул эдгээр байгууллагуудад Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бүгдэд нь олгож болохгүй гэж үзэж байна.</p> <p>Иймд хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасан Энэ хуулийн 17.2.1-д заасан тусгай зөвшөөрлийг нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд...” олгоно гэсэн энэхүү зохицуулалтыг Монгол Улсын “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” MNS 4946 : 2019 стандартад заасан хоолны газрын ангилалаар ангилж томъёолох.</p> <p><b>11/ НАЙМ. Хуулийн төслийн 22 дугаар зүйл. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газар дараах утга агуулгатай хэсэг, заалтыг өөрчлөн найруулах болон нэмэлтээр оруулах</b></p> <p>22.1.7. арван наймаас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг анх батлагдсан зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж, тохижуулснаас бусад орон сууц, түүний суурийн давхарт гэж өөрчлөх</p> <p>22.1.9. Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 3.1.4-т заасан газар гэж өөрчлөх</p> <p>22.1.10. хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувиллын газрын барилга, эдэлбэр газраас гадагш 500 метрийн радиуст; гэж нэмэх.</p> <p><b>12/ ЕС. Хуулийн төслийн 26 дугаар зүйл. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах тусгай шаардлагад дараах хэсэг, заалтыг нэмэлтээр оруулах</b></p>	<p>11.Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>12.Саналууд зарчмын хувьд туссан болно. төслийн 26.6- д такси, нийтийн тээврийг үйлчилгээний мэдээллийг үйлчилгээний танхимд байршуулахаар заасан. Мөн 35 дээш хувийн этилийн спирт агуулсан согтууруулах ундааг савалгаатайгаар бус зөвхөн хундагалж үйлчлэхээр тусгасан болно.</p> <p>13.Төслийн 32.1.2.т төрийн бэлгэ тэмдэг, түүхэн хүний нэр, зургийг, согтууруулах ундааны нэр, лого, барааны тэмдэг, зураг, сурталчилгаанд ашиглахыг хориглосон заалт туссан. Согтууруулах ундаа сурталчлах зорилгоор хандив, тусламж өгөхийг хориглосон.</p>
--	--	--	---

		<p>26.7. Согтууруулах ундаагаар үйлчлүүлж согтсон үйлчлүүлэгчид такси болон дуудлагын тээврийн үйлчилгээ дуудаж үйлчилнэ гэж нэмэх.</p> <p>26.8. Согтууруулах ундааны зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор нэг ширээ эсхүл нэг хүнд үйлчлэх согтууруулах ундааны дээд хязгаарыг тогтооно гэж нэмэх.</p> <p><b>13/ АРАВ. Хуулийн төслийн 32 дугаар зүйлд дараах утга агуулгатай хэсэг заалтыг нэмэх</b></p> <p>32.. .Согтууруулах ундааны борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний бэлгэдэл, улс үндэстний түүхэнд мөнхөрсөн хувь хүний зураг, дүрс, нэр бүхий лого, брэнд нэр, бүтээгдэхүүний нэр үүсгэхийг хориглоно.</p> <p>32.. ..Согтууруулах ундаа үйлдвэрлэгч нь эрүүл мэндийн болон хүүхдийн байгууллагад аливаа хэлбэрээр хандив, тусламж өгөх, эдгээр байгууллагад ажиллагсадыг санхүүгийн болон бусад байдлаар ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэхийг хориглоно.</p> <p>32.. .Согтууруулах ундааны борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор төөрөлдүүлэх санаа, утга агуулсан хэллэг бүхий зар сурталчилгааг хориглоно.</p> <p>32.. .Согтууруулах ундааны нэр, барааны тэмдэг, лого, бусад ялгарах онцлогийг энэ хуулийн хүрээнд хамаарахгүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглахыг хориглоно.</p> <p><b>14/ АРВАН НЭГ.Хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулж, шинэ хэсэг нэмэх</b></p> <p>34.1 .Бүх төрлийн согтууруулах ундааг сурталчилахыг хориглоно гэж өөрчлөн найруулах</p> <p>34.4.Согтууруулах ундааны сав, баглаа боодол, шошго дээр бүтээгдэхүүний агууламж нь хүний эрүүл мэнд эерэг нөлөөтэй гэсэн агуулга бүхий мэдэгдэл байршуулахыг хориглоно гэж нэмэх.</p> <p><b>15/ АРВАН ХОЁР.Хуулийн төслийн 37 дугаар зүйлд доорх утга агуулгатай хэсэг нэмэх</b></p>	<p>Мөн төөрөгдүүлэх санаа, утга агуулахгүй байхыг Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан болно.</p> <p>Мөн төслийн 32.1.11-д согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгөөс бусад газарт эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэхийг хориглосон.</p> <p>14.Саналуудыг анхаарсан. Согтууруулах ундааны шошгонд тавигдах шаардлага, анхааруулгын загварыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар тусгасан.</p> <p>15. Заавал тусгах шаардлагагүй бөгөөд зохицуулалт нь бусад хууль тогтоомжоор шийддэгдэх боломжтой гэж үзэв.</p>
--	--	--	--

		37.3.Согтууруулах ундааг хэтрүүлсэн хэрэглэсний улмаас хордлогод орсон этгээд өөрийн болон ойр дотны хүний санаачилгаар эмнэлгийн байгууллагад хандаж эмчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.4-т заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.	
10.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2020.09.28 02/2365	<p>Танаас ирүүлсэн “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, танилцуулгатай танилцлаа.</p> <p>А.Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Согтууруулахундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савлагаатай нь худалдах, түүгээр үйлчлэх хориглоно” гэжээ. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий газарт архи ба хатуулаг өндөртэй бүтээгдэхүүнийг граммлан худалдаалах эсвэл шилтэй бүтээгдэхүүнийг нь өөр саванд юүлэн үйлчлэх шаардлага үүсэж болзошгүй бөгөөд энэ нь дараах эрсдэлийг бий болгоно. Тухайлбал:</p> <p>1.Ариун цэвэр,эрүүл ахуйн стандарт, шаардлага зөрчигдөх;</p> <p>2.Юүлэн хийх савыг (графин) цэвэрлэхэд хүндрэлтэй, удаашралтайгаас үүдэн үйлчлүүлэгчид дутуу цэвэрлэсэн саванд үйлчлэх, ариун цэврийн норм норматив алдагдана;</p> <p>3.Хямд үнэтэй архи, согтууруулах ундааны төрлийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэх эрсдэлтэй бөгөөд үүнээс шалтгаалж хэрэглээний хэмжээ эрс өснө;</p> <p>4.Хэрэглэгчийн үлдээсэн бүтээгдэхүүнийг хольж, хяналтгүйгээр орлого олох боломжийг бий болгох эрсдэлтэй байна.</p> <p>Б.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д “аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа байршуулахыг хориглоно”, мөн зүйлийн 32.1.10-д “согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч соёл, урлаг, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, ивээн тэтгэлэг үзүүлэхийг хориглоно” гэж заажээ. Соёл урлаг, спортын салбарын</p>	<p>А.Согтууруулах ундааны зохистой хэрэглээг бий болгох зорилгоор олон улсад нэвтэрсэн үйлчилгээний стандартыг тусгасан тул саналыг авах боломжгүй болно.</p> <p>Б.Саналыг анхаарсан болно.</p>

		<p>хөгжилд хөрөнгө оруулагчид, дэмжигчид голлох үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тэрхүү санхүүгийн дэмжлэгийг нь үзүүлэх чадалтай цөөхөн хэдэн салбар бий. Тухайлбал, уул уурхай, газрын тос, шингэн хүнс зэрэг. Хуулийн төсөлд энэхүү заалт тусгагдаж батлагдсанаар тухайн салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байх тул анхаарах шаардлагатай байна.</p> <p>В.Мөн хуулийн төслийн 24 дүгээр зүйлд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдрүүдийн талаар дурджээ. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдрийг ихэсгэснээр энэ төрлийн бизнес эрхлэгчдэд эдийн засгийн болон бусад сөрөг үр дагавартай байх тул тэдгээр бүтээгдэхүүнийг худалдах татварыг нэмэх зэрэг хуулийн зохицуулалтуудаар асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналтай байна.</p>	<p>В.Саналыг анхаарсан болно. Архигүй өдрүүдийн тоог бууруулсан.</p>
11.	Соёлын яам 2020.09.23 1а/330	<p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох баримт бичигтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна:</p> <p>1.Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар албан хэрэгцээндээ зориулж Монгол Улсын хилээр согтууруулах ундаа нэвтрүүлэх нь ойлгомжгүй байгаа бөгөөд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.10-т “гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн салбарын албан хэрэгцээнд зориулан импортолсон бараа”-г гаалийн татвараас чөлөөлөхөөр заасан байдаг тул төслийн 4.1.3 дахь заалтыг хасах;</p> <p>2.Засгийн газрын олгосон тусгай зөвшөөрлийн хугацааг Засгийн газрын гишүүн сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгох нь зохимжгүй тул төслийн 5.2. дахь хэсгийг хасаж, 5.1-ийг өөрчлөн найруулах;</p> <p>3.Төслийн 5.4 дэх хэсгийн “хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн” гэснийг хасах;</p>	<p>1.Саналыг анхаарсан болно.</p> <p>2.Тусгай зөвшөөрөл сунгах, сэргээх бүрт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлага үүсэх тул саналыг авах шаардлагагүй гэж үзсэн.</p> <p>4.Саналыг анхаарч,холбогдох өөрчлөлтийг оруулсан болно.</p>

	<p>4.төслийн 9.1.2 нь 10.2.6, 9.1.3 нь 10.2.8, 9.1.4 нь 10.2.3, 10.2.11 дэх заалтуудтай давхардаж, хийдэл үүсгэж болзошгүй тул дахин нягталж, өөрчлөн найруулах, эсхүл төслийн 9 дүгээр зүйлийн дээрх заалтуудыг хасах;</p> <p>5.төсөлд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх түр зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдөх тул төслийн 20 дугаар зүйлийг хасах эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд тодорхой тохиолдлуудад буюу хурим, найрын арга хэмжээнд зөөврийн үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг төсөлд тусгах;</p> <p>6.төслийн 20.1 дэх хэсэг нь төслийн 22.1.5, 32.1.1 дэх заалтуудтай зөрчилдөх тул хасах;</p> <p>7.төслийн 5.3-т заасан чөлөөт бүсийн Захирагчийг төслийн 21.1 дэх хэсэгт нэмэх</p> <p>8.олон улсын иргэний агаарын тээвэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх нь түгээмэл тул төслийн 22.1.2 дахь заалтын “агаарын хөлөг” гэснийг хасах;</p> <p>9.гар дээрээс согтууруулах ундаа худалдахыг хориглох зохицуулалт төслийн 23.1.5, 23.1.8-д давхардаж байх тул өөрчлөх;</p> <p>10.Засаг дарга шийдвэрлэх нь зүйтэй тул төслийн 24.1 дэх хэсгийн хасаж, 24.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах, 25.3 дахь хэсгийн “өдрийн” гэснийг хасах;</p> <p>11.Хууль тогтоомжийн тухай хуулийн 17.2-т заасан хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож төслийн 13.3, 22.1.2, 22.1.7 32.1.13, 32.3-т шинжилгээ хийж, үнэлсэн эсэх;</p> <p>12.төслийн 30.1.2, 30.1.3 дахь заалтыг хасах;</p> <p>13.Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 3-т заасан Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй.”, 6.4 дүгээр зүйлийн 1-д заасан “согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэнтэй</p>	<p>5.Түр зөвшөөрөл олгох хэрэгцээ, шаардлага үүсдэг тул саналыг тусгах боломжгүй гэж үзэв.</p> <p>6.Саналыг анхаарсан болно. Саналыг авсан.</p> <p>7.Саналыг тусгасан болно.</p> <p>8.Агаарын хөлгийн зөвшөөрөгдсөн цэгээс гэж хязгаарлалттай байгаа болно.</p> <p>9.Саналыг анхаарч зассан.</p> <p>10.Саналыг анхаарсан болно.</p> <p>11.Саналыг анхаарсан болно.</p> <p>12.Саналыг авах шаардлагагүй гэж үзсэн болно.</p> <p>13.Саналыг анхаарсан, иргэний эрх зүйн хүрээнд гэм хорыг нэхэмжлэх боломжтой.</p>
--	--	--

		төслийн 30.3 зөрчилдөх тул хасах; 14.Төслийн хийдэл, зөрчлийг арилган, Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн төслийг дахин боловсруулах, төсөлд тусгагдаагүй “архигүй өдөр” ням гарагийг танилцуулгаас хасах.	14.Саналыг анхаарсан болно.
12.	Батлан хамгаалахын яам 2020.09.23 1а/3004	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналтай байна.  Хуулийн төслийн зохицуулах харилцаатай холбогдуулан хуулийн төслийн нэрийг Согтууруулах үндэсний эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль гэж өөрчлөх;  Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь заалтыг “согтууруулах ундааг дуудлагаар гэрийн хаяг болон бусад байрлалд хүргэх;” гэж өөрчлөн найруулах;  Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарлалтыг хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг дэх согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн төрөлд заасан хугацаатай уялдуулан тогтоох	1.Хуулийн төслийн нэрийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.  2.Санал зарчмын хувьд туссан.  3.Төслийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг аймаг нийслэлийн Засаг дарга тогтоодог байхаар өөрчилсөн.
13.	Боловсрол, шинжлэх ухааны яам 2020.10.02 1А/1918	Тусгайлан өгөх саналгүй байна.	Хуулийн төслийг дэмжсэн болно.
14.	Байгаль, орчин аялал жуулчлалын яам 2020.09.18 01/6403	Хуулийн төслийг дэмжиж байна.	Хуулийн төслийг дэмжсэн болно.

15.	Зам тээврийн хөгжлийн яам 2020.09.24 01/ 4514	Тусгайлан өгөх саналгүй болно.	Хуулийн төслийг дэмжсэн болно.
16.	Эрчим хүчний яам 2020.09.18 а/3000	Тусгайлан өгөх саналгүй болно.	Хуулийн төслийг дэмжсэн болно.
17.	Барилга, хот байгуулалтын яам 2020.10.09 01/3246	<p>1.Хуулийн төслийн 5.6 -д “ Сogтyуpуулax yндaа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглох бөгөөд үйлдвэрлэх cogтyуpуулax yндaаны нэр, үйлдвэрлэлийн байршлыг өөрчлөх, эсхүл шинэ нэр төрлийн cogтyуpуулax yндaа үйлдвэрлэхэд энэ хуулийн 5.1. 5.3т заасны дагуу тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулна гэж тусгасны “шинэ нэр” гэсэн нь хуулийн төслийн 11.4 дэх хэсэгтээ зөрчилдөж байгааг анхаарах.</p> <p>2.Хуулийн төслийн 25.1 хэсэг нь төслийн 17.2.2-т заасан хугацаатай зөрчилдөж байгааг анхаарах.</p> <p>3.Хуулийн төслийг дагалдан гарах Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 12-т заасан cogтyуpуулax yндaагаар шагнаж урамшуулах, эсхүл цалин хөлс орлуулж олгосон” гэсэн нь мөн зүйлийн 13-т заасантай зөрчилдөж байгааг анхаарах.</p>	<p>1.Саналыг анхаарсан болно. Хуулийн төслийн 11.4 дэх хэсэг найруулгын хувьд өөрчлөгдсөн болно.</p> <p>2.Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>3.Саналыг анхаарсан болно.</p>
18.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 2020.09.25	<p>Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Албадан эмчилгээг эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан гурваас зургаан сар хүртэл, давтан эмчлүүлэх тохиолдолд зургаан сараас нэг жил хүртэл хугацаатай хийнэ”, мөн зүйлийн 17.2 дахь хэсэгт “Албадан эмчлэх хугацаа нь эмчлүүлэгчийн эмчилгээний үр дүнг харгалзан мэргэжлийн эмч нарын зөвлөгөөний дүгнэлтийг үндэслэн гаргасан шүүхийн шийдвэрээр дуусгавар болно.” гэж тус тус заасан.</p> <p>Дээрх хуульд заасны дагуу Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх газар эмчлүүлэгчийг хүлээн авч 7-14 хоногт</p>	Саналыг тусгах боломжгүй. Албадан эмчилгээний хугацааг 2 жил хүртэл хугацаатай байхаар тусгав.

	01/4579	<p>архины хордлого тайлах, 21 хоног биеийн шинж тэмдгийн эмчилгээ, 1 сарын хугацаанд. архины харшил үүсгэх, архи зохихгүй болгох эмчилгээ болон сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтад хамруулдаг ба анх удаа эмчлэгдэж байгаа хүнд 3 сар, давтан эмчлэгдэж байгаа хүнд 6 сарын хугацаа шаардлагатай байдаг.</p> <p>Иймд Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “нэг жил” гэснийг “хоёр жил” гэж өөрчлөлт оруулж, эмчилгээний хугацааг 2 жил болгох нь эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлэхэд хүндрэл учрах, удаан хугацаагаар эмчилгээнд хамрагдсанаар өрхийн амжиргаа буурах, гэр бүл салах, албадан эмчилгээнээс зайлсхийх, оргох, гэмт хэрэг, зөрчил гаргах эрсдэлтэй тул хуулийн одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээх саналтай байна.</p>	
19.	Цагдаагийн ерөнхий газар 2020.09.24 01/687	<p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг тусгуулахаар хүргүүлэв. Үүнд:</p> <p>1.Төслийн 8.1 дэх хэсгийг “Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацааг гурван жилийн хугацаагаар олгож, тухай бүр 2 жилийн хугацаагаар сунгана.” гэж өөрчлөх;</p> <p>2.Төслийн 9.1 дэх хэсгээс 9.1.2 дахь заалтыг хасч, 10.2 дахь хэсэгт оруулах;</p> <p>3.Төслийн 10.2.3 дахь заалтыг “10.2.3.энэ хуулийн 42.2-т заасан онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа худалдсан, эсхүл онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч онцгой албан татварын тэмдэгт ашигласан, захиалгаар хийлгэсэн, хуурамч онцгой албан татварын тэмдэгт наасан архи, согтууруулах ундаа худалдан борлуулсан” гэж өөрчлөх;</p> <p>4.Төслийн 13.3 дахь хэсгийн “Гадаад улсад экспортлохоос” гэсний өмнө “Энэ хуулийн 13.1-д заасан шошгонд төрийн хүндэтгэлийн бэлгэ тэмдэг, сүлд, далбаа, Их эзэн Чингис хааны нэр, дүрс ашиглах,” гэж нэмэх, мөн хэсгийн “1,5 литрээс их” гэснийг “0,75 литрээс их” гэж, “1 литрээс их” гэснийг “0,5 литрээс их” гэж тус тус өөрчлөх;</p> <p>5.Төслийн 16.4 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгож, олгож, тухай бүр 5 жилийн хугацаагаар сунгах зохицуулалтыг 3 жилийн хугацаатай олгож, тухай бүр 2 жилийн хугацаатай</p>	<p>1.Тусгай зөвшөөрлийн олгох, сунгах хугацааг богиносгох шаардлагагүй гэж үзсэн болно.</p> <p>2.Санал туссан болно.</p> <p>4.Санал туссан болно.</p> <p>5.Тусгай зөвшөөрлийн хугацааг богиносгох шаардлагагүй болно.</p> <p>6.Хуулийн төслийн 25.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч</p>



		<p>сунгахаар өөрчлөх;</p> <p>6.Төслийн 16.8 дахь хэсгийн хүнсний, эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтоохоор заасан нормативыг хуульд тусгахаар өөрчлөн найруулах;</p> <p>7.Төслийн 17.2.2 дахь заалт нь мөн төслийн 25.1 дэх хэсэгтэй нийцэхгүй байх тул “14-00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх” гэж өөрчлөх;</p> <p>8.Төслийн 19.1.2 дахь заалтын “гурав, түүнээс дээш удаа зөрчсөн” гэснийг “хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн” гэж өөрчлөх;</p> <p>9.Төслийн 20.1 дэх хэсгийн “Олон нийтийг хамарсан хурим найр, ёслолын арга хэмжээ, урлагийн тоглолт, үзэсгэлэн худалдаа,” гэснийг хасах;</p> <p>10.Төслийн 20.3 дахь хэсэгт заасан түр зөвшөөрлийн хугацааг 20 хүртэл хоногоор нэг удаа олгохоор өөрчилж, 18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох талаар зохицуулалтыг тусгах;</p> <p>11.Төслийн 24.1 дэх хэсгийн “24.1.1.сар бүрийн эхний өдөр,” гэснийг “24.1.1.сар бүрийн эхний өдөр, долоо хоног бүрий ням гараг;” гэж өөрчлөх. Төслийн 30.1 дэх хэсэгт “30.1 өөрөөс нь өөр асран хамгаалагч харгалзан дэмжигчгүй бага насны хүүхэдтэй хүн, мөн бага насны хүүхэд асран халамжилж байгаа хүн” гэж нэмэх;</p> <p>12.Төслийн 40.7 дахь хэсэгт “40.7.4.согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх хууль тогтоомжийн биелэлтийн талаар шалгалт хийх.” гэж нэмэх;</p> <p>13.Төсөлд согтууруулах ундаагаар үйлчлэх, борлуулалтад хяналт тавих үүрэг хүлээсэн байгууллагаас хууль зөрчсөн талаар мэдэгдэл, шаардлагыг үндэслэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох зохицуулалтыг тусгах;</p>	<p>харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтоохоор тусгасан”.</p> <p>7.Санал туссан болно.</p> <p>8. Саналыг тусгах боломжгүй.</p> <p>10.Түр зөвшөөрөл олгохоор зохицуулж буй тул эдгээр үйл ажиллагааг хасахгүй байхаар үлдээв. хурим, найр гэснийг хассан болно.</p> <p>11.Ажлын хэсгийн хурлаас хууль бус архины худалдаа ихэсдэг тул “архигүй өдрийн” тоог цөөрүүлсэн.</p> <p>12.Санал туссан.</p> <p>13.Тусгай зөвшөөрлийн хүчингүй болгох, түдгэлзүүлэх журмыг Засгийн газар батлахаар тусгасан бөгөөд журамд саналаа өгч тусгах боломжтой.</p>
		<p>Нийслэлийн нутгийн захиргааны холбогдох байгууллагаас санал авч нэгтгэн хүргүүлэв</p>	<p>Хүний нөөцийн талаархи санал туссан.</p>

20.	Нийслэлийн засаг даргын тамгын газар 2020.10.09 02-01/5812	<p>“7.1.3. Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүнсний үйлдвэрлэлийн технологийн чиглэлээр мэргэжлийн хүний нөөцтэй байх” гэж өөрчлөх</p> <p>“7.1.9. Дотоодын хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлсэн байх” гэж нэмэх</p> <p>8.1. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгож, тухай бүр хоёр жилийн хугацаагаар сунгана.</p> <p>10.2.1. энэ хуулийн 6.1-д заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл тэдгээр нь худал мэдээлэл агуулсан болох нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон</p> <p>Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт дор дурдсан заалтыг нэмэх:</p> <p>10.2.1.Энэ хуулийн 12.5-т заасан хугацаа өнгөрөхөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоосон нөхцөл байдал арилаагүй</p> <p>Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд дор дурдсан хэсгийг нэмэх: 11.7.Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгч нь чанар, аюулгүй байдлын хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлсэн бүтээгдэхүүний нууцлал бүхий бүртгэлтэй, буцаан татах тогтолцоотой байна. Бүтээгдэхүүн, түүхий эд /спирт, зөөлрүүлсэн ус, буудай, соёолж, хөрөнгө, фермент, хүнсний нэмэлт зэрэг/-ийг итгэмжлэгдсэн сорилтын лабораториор шинжлүүлж, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт гаргуулна.</p> <p>Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1-д “... үйлдвэрлэлийн хүчин чадлын тодорхой хувиас доошгүй” гэснийг тодорхой тоон үзүүлэлтээр хуульчлах.</p> <p>13.1.7 үйлдвэрлэсэн болон хадгалагдах хугацаа, нөхцөл, цувралын дугаар;</p> <p>15.7. Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгож, тухай бүр хоёр жилийн хугацаагаар сунгана.</p> <p>16.4. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгож, тухай бүр хоёр жилийн хугацаагаар сунгана.</p> <p>Хуулийн төслийн 16 дугаар зүйлд дор дурдсан хэсгийг нэмэх: 16.9.Энэ хуулийн 16.1-т заасан эрхээ аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн</p>	<p>Дотоодын хяналтыг бүрдүүлэх санал 7.1.3-т туссан.</p> <p>Тусгай зөвшөөрлийн хугацааг төсөлд туссанаар үлдээхээр Ажлын хэсгийн хурал дээр шийдвэрлэсэн тул авах боломжгүй.</p> <p>Хуурамч мэдээлэлтэй холбоотой санал төсөлд туссан.</p> <p>Тогтоосон доод хэмжээндээ хүрч үйлдвэрлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох агуулга туссан болно.</p> <p>Санал туссан болно.</p> <p>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар зохицуулагдаж буй харилцаа.</p> <p>Тоон үзүүлэлтийг хүнснийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоохоор тусгасан.</p> <p>Саналыг тусгасан.</p> <p>Саналыг хүлээн аваагүй.</p> <p>Саналыг тусгасан.</p>
-----	--	--	---

	<p>Засаг дарга, харьяалах нутаг дэвсгэр дэх хотын Захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p>18.1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлд заасан хугацаа дуусч тусгай зөвшөөрөл эзэмшигч хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй, тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан бол тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох шийдвэрийг тусгай зөвшөөрөл олгосон этгээд гаргана.</p> <p>18.3. Согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 18.2-т заасан зөрчлийг арилгах хүртэл гурван сараас илүүгүй хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд түдгэлзүүлсэн үндэслэл арилсан талаарх энэ хуулийн 40.3.2, 40.3.4-т заасан байгууллага, албан тушаалтны тодорхойлолтыг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.</p> <p>Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг хасах.</p> <p>19.1.1. Тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл тэдгээр нь худал мэдээлэл агуулсан болохыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон.</p> <p>19.1.2. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх хуульд заасан өдөр, цагийн хязгаарыг 3 сарын хугацаанд хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн</p> <p>20 дугаар зүйл энэ зүйлийг хасах</p> <p>23.3. Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй баар, шөнийн цэнгээний газрыг хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, оюутан, сурагчдын хичээлийн байр, орон сууцнаас 150 метрийн зайд ажиллуулахыг хориглох</p> <p>22.1.3. гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэн, соёл, амралтын хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай, шатахуун түгээх газар, шашны байгууллагын байр, тэдгээрээс 50м доторх орчинд</p> <p>22.1.7. анх батлагдсан зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж, тохижуулснаас бусад орон сууц, түүний өргөтгөл, суурин давхар, орц, хонгил</p> <p>32.1.8. Согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, лого, барааны тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, олон нийтийн сүлжээ, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл,</p>	<p>Тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох харилцаа хуулийн төслөөс хасагдсан болно.</p> <p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг хуулийн төслийн 18.2-т тусгасан.</p> <p>Саналыг авах боломжгүй.</p> <p>Санал зарчмын хувьд хуулийн төсөлд туссан болно.</p> <p>Санал зарчмын хувьд хуулийн төсөлд туссан.</p> <p>\</p> <p>Түр зөвшөөрөл олгох хэрэгцээ шаардлага байдаг тул хасах боломжгүй.</p> <p>Санал зарчмын хувьд хуулийн төслийн 22.1.1- т туссан.</p> <p>Санал зарчмын хувьд хуулийн төслийн 22.1.3-т туссан.</p> <p>Санал зарчмын хувьд хуулийн төслийн 22.1.7-д туссан.</p> <p>Саналыг тусгасан.</p> <p>Санал зарчмын хувьд хуулийн төсөлд туссан.</p>
--	--	--

		<p>зорчигчийн тийз, хоолны цэс болон бусад биет байдлаар гаргах;</p> <p>Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6.5.5 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон газар, цаг хугацаанд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн, эсхүл согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хууль бусаар бусдад шилжүүлсэн, хариу төлбөртэйгээр ашиглуулсан бол... торгоно</p> <p>Зөрчлийн тухай хуульд Зөрчлийн тухай хуулийн 6.5.11.5. “худалдах, түүгээр үйлчлэх ажилд арван найман насанд хүрээгүй хүн ажиллуулсан, эсхүл 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыгхурааж, хүнийгхорин нэгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн хэсэгт өөрчлөлт оруулах</p> <p>Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 10 дугаар зүйлд “...хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр” гэснийг “хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх” гэж өөрчлөх.</p>	<p>Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>Саналыг тусгасан болно.</p>
21.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020.10.01 01/2646	<p>Дараах саналыг ирүүлэв:</p> <p>1.“Энэ хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, экспортлох, импортлох, реэкспортлох, худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэхэд оршино” гэх.</p> <p>2.“Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.” гэх</p> <p>3. 5.1. “Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон энэ хуулийн 5.4-д заасан тусгай зөвшөөрлийг төсөл сонгон шалгаруулах журмын дагуу томилогдсон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газар олгож, сунгах, хүчингүй болгоно.” гэх.</p> <p>4. 6.1.1 Согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичиг, эрүүл ахуйн дүгнэлт” гэх</p>	<p>1.Саналыг тусгасан болно.</p> <p>2.Саналыг тусгасан болно.</p> <p>3.Санал зарчмын хувьд туссан.</p> <p>4.Саналыг тусгах шаардлагагүй гэж үзсэн.</p>

		<p>5. 6.1.1.“Энэ хуулийн 6.1.1-д заасан баримт бичгийн жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно” гэх</p> <p>6. 9.1.5 гэж заалт нэмэх “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь 2 буюу түүнээс дээш удаа хүнсний чанар, стандартын шаардлагыг хангаагүй.” гэж нэмэх.</p> <p>7. 10.2.10 -ыг хасах</p> <p>8. 11 дүгээр зүйлд нэмэх “11.6. Үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх” гэж нэмэх 11.7. Дотоодын хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлсэн байх” гэж нэмэх “11.8. Сogтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгч нь чанар, аюулгүй байдлын хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлсэн бүтээгдэхүүний нууцлал бүхий бүртгэлтэй, буцаан татах тогтолцоотой байна” гэж нэмэх.</p> <p>9. 13.1.7 “Үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, нөхцөл, цувралын дугаар” гэх</p> <p>10. 14.1.2 “хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувилал, соёл урлагын газар, тэдгээрийн эзэмшил, ашиглалтад байгаа бүх төрлийн барилга байгууламж” гэх.</p> <p>11. 14.1.5 “Нийтийн зориулалттай орон сууц, орон сууцны орц, хонгил, өргөтгөл, суурийн давхар” гэх</p> <p>Экспортлох заалт нэмж оруулах</p> <p>12. 15.5, 15.9-д реэкспортлох гэж нэмэх.</p> <p>13. 16.4 “Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгож тухай бүр гурван жилийн хугацаагаар сунгана” гэх</p> <p>14. 16.7“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, худалдах, түрээслүүлэх болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчлөхийг хориглоно” гэх</p> <p>15. 17.3“Энэ хуулийн 17.2.1 -д заасан тусгай зөвшөөрлийг нийтийн хоолны ресторан, кафены чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд, 17.2.2-т заасан тусгай</p>	<p>5. Саналыг тусгасан болно.</p> <p>6. Хүчингүй болгох зохицуулалтад туссан тул авах боломжгүй.</p> <p>7.Үйлдвэрлэлийн доод хэмжээтэй холбоотой заалтыг хасах саналыг хүлээн авах боломжгүй.</p> <p>8.Төслийн 11 дүгээр зүйлд дотоод хяналтын тогтолцоо, буцаан татах тогтолцоог бүрдүүлэх талаар зохицуулалт туссан болно.</p> <p>9. Саналыг тусгасан болно.</p> <p>10.Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>11.Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>12.Саналыг зарчмын хувьд тусгасан болно.</p> <p>13.Тусгай зөвшөөрлийн хугацааг багасгах шаардлагагүй гэж үзсэн.</p> <p>14.Санал зарчмын хувьд туссан.</p>
--	--	---	---

		<p>зөвшөөрлийг нийтийн хоолны баарны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдэд олгоно” гэх</p> <p>16. 18.4.ыг хасах.</p> <p>17. 19.1.5. Тусгай зөвшөөрлийг худалдах, түрээслэх зэргээр бусдад шилжүүлсэн, хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчилсөн” гэх</p> <p>18. 19.1-д нэмэх “19.1.13. 21 насанд хүрээгүй, эсхүл согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн нь тогтоогдсон бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.” гэж нэмэх</p> <p>19. 20 дугаар зүйлийг хасах.</p> <p>20. 22.1.7-г анх батлагдсан зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж, тохижуулсанаас бусад орон сууц, түүний өргөтгөл, суурийн давхар” гэх</p> <p>21. 22.1.9 “Бүх шатны сургууль, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, түүнээс 150 метрийн дотор” гэх.</p> <p>22. 22.3. “сунгахгүй” гэснийг дахин сунгахгүй” гэх.</p> <p>23. 28.4. Энэ хуулийн 28.1-д заасан баримт, бичигт иргэний үнэмлэх, гадаад паспорт болон жолоочийн үнэмлэх хамаарна.” гэх.</p> <p>24. 32.1.3 “тараах” гэж нэмэх.</p> <p>25. 32.1.8.”хоолны цэс” гэж нэмэх.</p> <p>26. 40 дүгээр зүйлийн гарчгийг “Үйлдвэрлэл, экспорт, импорт, реэкспорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хяналт” гэж өөрчлөх.</p> <p>27. 40.2-т “экспорт, реэкспортод” гэж нэмэх.</p> <p>28. 40.6-т “реэкспортод” гэж нэмэх.</p>	<p>15.Санал зарчмын хувьд туссан.</p> <p>16.Саналыг авах шаардлагагүй гэж үзсэн.</p> <p>17.Санал зарчмын хувьд туссан.</p> <p>18.Санал төслийн 19.1.9-д зарчмын хувьд туссан.</p> <p>19.20 дугаар зүйлийг хасах шаардлагагүй. эдгээр үйл ажиллагааны үед зарим төрлийн согтууруулах ундаагаар үйлчлэх хэрэгцээ шаардлага үүсдэг тул харилцааг зохицуулах шаардлагатай.</p> <p>20.Санал зарчмын хувьд туссан болно.</p> <p>21.Саналыг тусгасан болно.</p> <p>22.Тус хэсэг хасагдсан.</p> <p>23. Санал 28.5-д туссан болно.</p> <p>25. хоолны цэс гэж нэмсэн. Санал туссан болно.</p> <p>26.Саналыг тусгасан болно.</p> <p>27.Саналыг тусгасан болно.</p> <p>28. Саналыг тусгасан болно.</p>
		Дараах саналтай байна.	

22.	Гаалийн ерөнхий газар 2020.10.13 01/3531	<ol style="list-style-type: none"> <li>1. 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг “ашиг олох зорилгогүй, зорчигчийн хувийн хэрэглээний согтууруулах ундааг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх” гэж өөрчлөх.</li> <li>2. Төслийн 4.2 дахь заалтын “4.1.2” гэснийг хасах.</li> <li>3. Төслийн 15.3 дахь заалтыг “импортлох тусгай зөвшөөрөл авах зорилгоор согтууруулах ундааны дээжийг мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлэхээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх үед мэргэжлийн хяналтын болон гаалийн хяналт шалгалтад хамруулж баталгаажуулсан байна” гэж найруулах.</li> <li>4. Төслийн 32 зүйлд “ 32.4 Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 10 ба түүнээс ихгүй хувь нь согтууруулах ундаатай холбоотой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна гэсэн заалт нэмэх.</li> </ol>	<p>1.Санал туссан болно.</p> <p>3.Санал зарчмын хувьд туссан.</p> <p>4.Саналыг тусгаагүй болно.</p>
23.	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим 2020.10.02	<p>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн төсөлд МҮХАҮТ-аас өгөх санал:</p> <p>1.Төслийн 13 дугаар зүйлийн “13.3 Гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд 18 хүртэл хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 1,5 литрээс их, 18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 0,33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр болон хуванцар сав /лонх/-нд савлахыг хориглоно” гэснийг <i>Гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд 18 хүртэл хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 2 литрээс их хэмжээгээр савлахыг хориглоно</i>”, “Гадаад улсад экспортлох, агаарын хөлгийн үйлчилгээ, татваргүй барааны дэлгүүр, зочид буудлын хэрэгцээнд, тусгай зориулалтаар захиалгаар нийлүүлэхээс бусад тохиолдолд 18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 0,33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр савлахыг хориглоно” гэсэн хоёр заалт болгон өөрчлөн найруулах</p> <p>Үндэслэл: Энэхүү заалт тухайн төрлийн бизнес эрхлэгчид, бэлтгэн нийлүүлэгч</p>	<p>1.Санал төслийн 13 дугаар зүйлд туссан болно.</p>

	01/1039	<p>(савны бэлдэц, хаяг, шошго, бөглөө, хайрцаг сав нийлүүлэгч г.м) нарт олон эрсдэлийг үүсгэхээр байна. Шар айраг үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ 2 литр, 2.4 литр, 2.5 литрийн хэмжээтэй савладаг бөгөөд уг хэмжээ тус бүрээр тусгайлсан хэв ашигладаг. Нэг хэв дунджаар 300 мянган ам.долларын өртөгтэй бөгөөд 1 сая ширхэг сав үйлдвэрлэх хүчин чадалтай, ойролцоогоор 5 жил ажиллах ашиглалтын хугацаатай байдаг. Гэтэл хуулиар савлагааны хэмжээнд хориглолт хийснээр, нэгэнт худалдан авсан хэв ашиглагдахгүй болж, бизнес эрхлэгчдийн их хэмжээний хөрөнгө оруулалт үнэгүйдэх, ашиглалтаас гарах, дотоодын үйлдвэрлэгчид болон кластер хэлбэрийн бэлтгэн нийлүүлэгчдийн ердийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, үйлдвэрийн бүтээмж буурч, сул зогсолт үүсэх, цаашилбал, ажлын байр цомхтголд орох зэрэг сөрөг үр дагавартай байна. Ер нь савлагааг өөрчлөх нь архидан согтуурахтай тэмцэхэд үр нөлөөгүй гэж үзэж байна.</p> <p>18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг гадаад улсад экспортлохоос гадна агаарын хөлгийн үйлчилгээ, татваргүй барааны дэлгүүр, зочид буудлын хэрэгцээнд 0.33 литрээс бага хэмжээний савлагаатай тусгай захиалгын үндсэн дээр нийлүүлдэг. Энэхүү хэрэгцээ цаашид ч хэвээр байх тул үүнийг хуулиар хориглосноор дотоодын үйлдвэрлэгчдээс бус импортын бүтээгдэхүүнээр орлуулан авах шаардлага үүснэ. Нөгөө талаас энэ нь үнэ өндөр бүтээгдэхүүн тул хэрэглээ бага байдаг.</p> <p>2.Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд “Энэ хуулийн 13.3 дах заалтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэсэн заалт нэмж оруулах</p> <p>3.Хуулийн төслийн 13 дугаар зүйлд “Энэ хуулийн 13.3-т заасан согтууруулах ундааг хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан стандартад нийцсэн нийлэг саванд савлаж болно” гэсэн заалтыг нэмж оруулах</p> <p>Үндэслэл: Төсөлд “хуванцар сав” гэж ерөнхий нэрлэсэн нь хууль хэрэглээний явцад эргэлзээтэй байдлыг мөн үүсгэж болзошгүй юм. Тухайлбал, олон улсын стандартаар “хуванцар” савыг хүнсний аюулгүй байдлын шинж, хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үзүүлэлтээр нь 7-8 төрөлд ангилдаг бөгөөд дэлхийн бүхий л улс орнууд хүнсний аюулгүй байдлыг хангасан, эрүүл ахуйн шаардлага хангасан</p>	<p>2.Савалгааны хэмжээ мөрдөгдөх хугацааг 2025 оноор тусгасан болно.</p> <p>3. Нийлэг саванд савлахыг зөвшөөрөх боломжгүй.</p>
--	---------	---	--



		<p>хуванцар буюу нийлэг саванд согтууруулах ундааг савлаж байна. Монгол Улс 2016 онд Европын холбооны улсуудын стандартыг үндэслэн, MNS 0179:2016 “Цагаан болон өвөрмөц архи, техникийн ерөнхий шаардлага” стандартаар архийг хуванцар саванд савлахыг зөвшөөрсөн.</p> <p>4.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.6. “Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд нэг жилд импортлох согтууруулах ундааны нэр, төрөл бүрийн хэмжээ нь өмнөх жилд Монгол Улсад үйлдвэрлэсэн тухайн нэр, төрлийн согтууруулах ундааны 30 хувьтай тэнцэх хэмжээнээс илүүгүй байна” гэснийг хасах</p> <p>Үндэслэл: Импортлох согтууруулах ундааны хэмжээг дотооддоо үйлдвэрлэсэн согтууруулах ундааны 30 хувиар тогтоох нь тодорхой үндэслэлгүй, квотын судалгаагүйгээр тогтоосон байна. Нэг аж ахуйн нэгжийн борлуулалтаар нөгөө аж ахуйн нэгжийн импортын хэмжээг тогтоож байгаа нь бизнесийн шударга өрсөлдөөнд харшилна. Импортын бүтээгдэхүүн хууль бусаар оруулж ирдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих бус тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийнхээ хуулийг чангатгах нь зохимжгүй юм. Ер нь импортын татвараар л импортын квотыг шийдвэрлэх бөгөөд согтууруулах ундааны импортын онцгой албан татварын хувь хэмжээ хангалттай өндөр байгаа гэж үзэж байна.</p> <p>Импортын тоо хэмжээг урьдчилж мэдэх, хязгаарыг тогтоох чиглэлээр бусад улсуудын туршлагыг харгалзан үзэх шаардлагатай. Тухайлбал, ОХУ-ын хувьд, импортоор оруулж ирэх согтууруулах ундааны тоо хэмжээнд ногдох татвар, төлбөрөө зохих хэмжээгээр төлсний үндсэн дээр “онцгой албан татварын тэмдэг буюу акц”-ыг урьдчилан худалдан авч, экспортлогч улс руу илгээн нийлүүлэх бүтээгдэхүүнд акцыг нааж үйлдвэрлүүлэн нийлүүлдэг туршлага байна.</p> <p>5.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7. “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, худалдах, хариу төлбөртэйгөөр ашиглуулах болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчлөхийг хориглоно” гэсэн заалтаас “<i>хариу төлбөртэйгээр ашиглуулах</i>” гэснийг хасах</p>	<p>4.Импортлох согтууруулах ундааны квот тогтоох тухай заалт хасагдсан болно.</p> <p>Онцгой албан татварын тэмдэг Дээр импортлогчийн таних боломжтой байхаар хуулийн төсөлд туссан болно.</p> <p>5.Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг бусдад төлбөртэйгөөр ашиглуулахыг хориглосон агуулга хасагдсан болно.</p> <p>6.Талбай, цэцэрлэгт хүрээлэн гэснийг нийтлэг байдлаар бус нийтийн эзэмшлийн гэж тодорхойлж өгсөн. Шатахуун</p>
--	--	--	--

		<p>6.Төслийн 22 дугаар зүйлийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газарт гэсэн 1 дэх хэсгийн “22.1.3 Гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай, шатахуун түгээх газар, шашны байгууллагын байр” гэж зааснаас “Талбай, цэцэрлэгт хүрээлэн” гэснийг хасах, “шөнийн 00.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл согтууруулах ундааг шатахуун түгээх газарт худалдах, цагийн хязгаарлалтаас үл хамааран шатахуун түгээх газарт согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох” агуулгаар өөрчлөн найруулах</p> <p>7.Төслийн 22 дугаар зүйлийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газарт гэсэн 1 дэх хэсгийн “22.1.7 Анх батлагдсан зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж, тохижуулснаас бусад орон сууц, түүний суурийн давхар” гэж зааснаас “анх батлагдсан зураг төсөл нь” гэснийг хасах</p> <p>8.Төслийн 22 дугаар зүйлийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газарт гэсэн 1 дэх хэсгийн “22.1.9 Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, түүнээс 100 метрийн дотор” гэж оруулснаас “түүнээс 100 метрийн дотор” гэснийг хасах</p> <p>9.Төслийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хориглохоор “23.1.5 Согтууруулах ундааг зайнаас /холбоо, олон нийтийн мэдээллийн сүлжээ ашиглан/ болон өөртөө үйлчлэх автомат төхөөрөмж ашиглан, эсхүл гар дээрээс худалдах, түүгээр үйлчлэх”; “23.1.6. Согтууруулах ундааг гэрийн хаягаар хүргэх” заасныг “тодорхой хэмжээ, хязгаар тавьсны үндсэн дээр онлайнаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлүүлэх нөхцөлийг зөвшөөрөх” агуулгаар өөрчлөн найруулах</p> <p>10.Төслийн 24 дүгээр зүйлийн “24.1.Дараах өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно” гэснийг эргэн харж энэ өдрүүдийг хасах.</p> <p>11.Төслийн 25 дугаар зүйлийн “25.1 Хуульд өөрөөр заагаагүй бол 00-11 цагийн хооронд согтууруулах ундаа худалдахыг хориглоно” гэсэнтэй холбогдуулан 25 дугаар зүйлд Энэ хуулийн 25.1 дэх заалт татваргүй барааны дэлгүүрийн горимд хамаарахгүй” гэсэн заалтыг нэмж тусгах</p>	<p>түгээх газарт цагийн хязгаарлалттайгаар согтууруулах ундаа худалдахтай холбоотой саналыг хүлээж авах боломжгүй.</p> <p>7. Анх батлагдсан зураг төсөл гэснийг хасах санал ирүүлснийг авах боломжгүй.</p> <p>8.Хэрэгжих боломжгүй гэж үзсэн тул 100 метрээр хязгаарлалт хасагдсан болно.</p> <p>9.Согтууруулах ундаа нь худалдан авагчийн тодорхой нөхцлүүдийг тогтоосны улмаас худалдах онцгой бүтээгдэхүүн тул хүргэлтээр, зайнаас худалдах агуулгыг зөвшөөрөх боломжгүй. Энэ нь зөвхөн хэрэглэгчид хамаарах зохицуулалт бөгөөд согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн хооронд үүсэх харилцаанд хамаарахгүй юм.</p> <p>10.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдөр 9 байсныг 4 болгож цөөрүүлсэн.</p>
--	--	---	---

	<p>12.Төслийн 26 дугаар зүйлийн “26.3. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савлагаатай нь худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно” гэсэн заалтыг хасах.</p> <p>13.Төслийн 32 дугаар зүйлийн “32.1.1 Аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулахыг хориглоно” гэж заасныг <i>32.1.1 Зар сурталчилгааны тухай хуулийн 14<sup>1</sup>.4-т зааснаас бусад тохиолдолд аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах</i>” гэж найруулах</p> <p>14.Төслийн 32 дугаар зүйлийн “32.1.4 Согтууруулах ундаагаар дээж, загвар хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчлэх, бүсдэг дайлах, амталгаа зохион байгуулахыг хориглохоор” заасныг хасах.</p> <p>15.Төслийн 32 дугаар зүйлийн “32.1.11 Эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх”-ийг хориглохоор заасныг <i>“32.1.11 Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад газарт эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх”</i> гэж өөрчлөн найруулах</p> <p>16.Дагалдах хуулийн төсөл болох Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup> дэх зүйлийн “21<sup>2</sup>.2 Донтох өвчний хор уршигтай тэмцэх үүргийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан эх үүсвэр болон спирт, согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөс бүрдэнэ” гэж заасныг <i>“21<sup>2</sup>.2 Донтох өвчний хор уршигтай тэмцэх үүргийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан эх үүсвэр болон согтууруулах ундааны онцгой албан татварын тодорхой хувиар бүрдэнэ”</i> гэж өөрчлөн найруулах Мөн сангийн нэрийг <i>“Архидан согтуурахтай тэмцэх үүргийн сан”</i> гэсэн агуулгаар тодорхойлж, архидан согтуурахын сөрөг үр нөлөө, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байдлаар нэрлэж, сангийн</p>	<p>11.Татваргүй барааны дэлгүүрт хамаарахгүй байхаар тусгасан.</p> <p>12.Олон улсад мөрдөгддөг үйлчилгээний стандарт бөгөөд хасах боломжгүй.</p> <p>13.Согтууруулах ундаа сурталчлахгүйгээр ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх боломжтой.</p> <p>14.Зохицуулалт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хооронд үүсэх бүтээгдэхүүн танилцуулах харилцаанд хамаарахгүй бөгөөд зөвхөн согтууруулах ундаа хуралдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд болон хэрэглэгчид хамаараалтай зохицуулалт юм.</p> <p>15.Санал зарчмын хувьд туссан.</p>
--	---	--

		<p>зориулалтын хувьд зөвхөн донтох өвчний хор уршигтай тэмцэх бус дараах агуулгаар өргөн хүрээнд тодорхойлох саналтай байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмнэлгийн болон эрүүлжүүлэх үйлчилгээ;</li> <li>- Соён гэгээрүүлэх;</li> <li>- Хөдөлмөр эрхлэх, нийгэмшүүлэхэд туслалцаа үзүүлэх, мэргэжил ур чадварын сургалтад хамруулах, ажлын байранд зуучлах;</li> <li>- Технологи, чанар, стандартын шаардлага хангаагүй, зөвшөөрөлгүй, зохих ёсоор зөвшөөрөгдөөгүй, холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлөөгүй, хуурамч бүтээгдэхүүн, хууль бус зах зээлтэй тэмцэх ажпыг санхүүжүүлэх;</li> </ul> <p>Дагалдах хуулийн төсөл болох Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup> дэх зүйлийн “21<sup>2</sup>.3. Энэ хуулийн 21<sup>2</sup>.2-т заасан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна” гэсэн заалтыг хасах</p> <p>Дагалдан гарах хуулийн төсөл болох Зар сурталчилгааны тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1</sup>.6-д “Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэл 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа нэвтрүүлж болно” гэж нэмэх.</p>	<p>16.Саналыг зарчмын хувьд тусгасан болно.</p> <p>Хуулийн төвлөрүүлэх согтууруулах хатуулагаас тогтоохоор тусгасан болно. этгээдээс хөрөнгийг ундааны хамааруулж тусгасан болно.</p>
24.	Монголын Хүнсчдийн холбоо 2020.10.01 85	<p>Дараах саналтай байна.</p> <p>1.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3-т гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд 18 хүртэл хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 1.5 литрээс их хэмжээгээр савлахыг хориглохоор заасан нь тухайн төрлийн бизнес эрхлэгчид, бэлтгэн нийлүүлэгч (савны бэлдэц, хаяг, шошго, бөглөө, хайрцаг сав нийлүүлэгч г.м) нарт дараахь эрсдэлийг үүсгэхээр байна. Үүнд:</p> <p>Шар айраг үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ 2 литр, 2.4 литр, 2.5 литрийн хэмжээтэй савладаг бөгөөд уг хэмжээ тус бүрээр тусгайлсан хэв ашигладаг. Нэг хэв дунджаар 300.000 ам.долларын өртөгтэй бөгөөд 1 сая ширхэг сав үйлдвэрлэх, ойролцоогоор 5 жил ажиллах ашиглалтын хугацаатай байдаг.</p> <p>Гэтэл хуулиар савлагааны хэмжээнд хориглолт хийснээр нэгэнт худалдан авсан хэв ашиглагдахгүй болж бизнес эрхлэгчдийн их хэмжээний хөрөнгө оруулалт үнэгүйдэх, ашиглалтаас гарах, дотоодын үйлдвэрлэгчид болон кластер хэлбэрийн бэлтгэн нийлүүлэгчдийн ердийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, үйлдвэрийн</p>	<p>1.18 хүртлэх хувийн хатуулагтай этилийн спирт агуулж буй согтууруулах ундааг 2 литрээс их хэмжээгээр савлахгүй байх саналыг тусгасан болно.</p>

	<p>бүтээмж буурч, сул зогсолт үүсэх, цаашилбал, ажлын байр цомхотголд орох зэрэг сөрөг үр дагавартай байна.</p> <p>Мөн 1,5 литрийн шинэ хэв захиалах, тоног төхөөрөмжийн тохиргоо хийхэд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, түүнтэй холбоотой бусад ажилд зохих хугацаа шаардагдах нь ойлгомжтой юм.</p> <p>Иймд үйлдвэрлэгчид, бэлтгэн нийлүүлэгчдийн бизнесийн хэвийн ажиллагааг алдагдуулахаас сэргийлж, савлагааны хэмжээг өөрчлөх зохицуулалтыг хасах, эсхүл бизнес эрхлэгч нарт шилжилтийн үеийн тодорхой хугацаа олгож, үе шатгайгаар шийдвэрлэх саналтай байна.</p> <p>Үүнтэй уялдуулан төслийн 13 дугаар зүйлийн 13.3-ыг дараахь агуулгаар өөрчлөн найруулах саналтай байна. Үүнд:</p> <p>Төслийн “13.3.Гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд 18 хүртэл хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 2 литрээс их хэмжээгээр савлахыг хориглоно.”</p> <p>2.Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд “Энэ хуулийн 13.3 дахь заалтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэсэн заалт оруулах саналтай байна.</p> <p>3.Мөн төслийн 13.3-т Гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд 18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 0,33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр болон хуванцар сав /лонх/-нд савлахыг хориглохоор заасан нь дараах эрэлтийг нийлүүлэх боломжийг хааж байна.</p> <p>18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг гадаад улсад экспортлохоос гадна агаарын хөлгийн үйлчилгээ, татваргүй барааны дэлгүүр, зочид буудлын хэрэгцээнд 0.33 литрээс бага хэмжээний савлагаатай тусгай захиалгын үндсэн дээр нийлүүлдэг.</p> <p>Энэхүү хэрэгцээ цаашид ч хэвээр байсаар байх тул хуулиар хориглосноор дотоодын үйлдвэрлэгчдээс бус импортын бүтээгдэхүүнээр орлуулан авах шаардлага үүсч, валютын гадагш урсгалыг дэмжих эрсдэлтэй байна.</p> <p>Иймд төслийн 13.3-т тусгасан дээрх агуулгыг 13.4 дэх заалт болгож, дараах агуулгаар өөрчлөн найруулах саналтай байна:</p> <p>“13.4.Гадаад улсад экспортлох, агаарын хөлгийн үйлчилгээ, татваргүй барааны дэлгүүр, зочид буудлын хэрэгцээнд, тусгай зориулалтаар захиалгаар нийлүүлэхээс бусад тохиолдолд 18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 0,33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр савлахыг</p>	<p>2.Саналыг тусгасан болно.</p> <p>3.Саналыг тусгах боломжгүй. Нийлэг савалгааг зөвшөөрсөн агуулга тусгах шаардлагагүй гэж үзсэн.</p> <p>Монгол Улс 2016 оны MNS 0179:2016 “Цагаан болон өвөрмөц архи, техникийн ерөнхий шаардлага”-д савалгааны материалыг заасан.</p>
--	---	--

		<p>хориглоно.”</p> <p>Түүнчлэн төсөлд “хуванцар сав” гэж ерөнхий нэрлэсэн нь хууль хэрэглээний явцад эргэлзээтэй байдлыг мөн үүсгэж болзошгүй юм. Тухайлбал, олон улсын стандартаар “хуванцар” савыг хүнсний аюулгүй байдлын шинж, хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үзүүлэлтээр нь 7-8 төрөлд ангилдаг бөгөөд дэлхийн бүхий л улс орнууд хүнсний аюулгүй байдлыг хангасан, эрүүл ахуйн шаардлага хангасан хуванцар буюу нийлэг саванд согтууруулах ундааг савлаж байна. Монгол Улс 2016 онд Европын холбооны улсуудын стандартыг үндэслэн, ММЗ 0179:2016 “Цагаан болон өвөрмөц архи, техникийн ерөнхий шаардлага” стандартаар архийг хуванцар саванд савлахыг зөвшөөрсөн.</p> <p>Иймд төслийн 13 дугаар зүйлд дараахь агуулгатай 13.5-р заалтыг нэмэх саналтай байна. Үүнд:</p> <p>“13.5. Энэ хуулийн 13.3, 13.4-т заасан согтууруулах ундааг хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан стандартад нийцсэн нийлэг саванд савлаж болно.”</p> <p>4.Төслийн 15 дугаар зүйлийн 15.6-д нэгжилд импортлох согтууруулах ундааны нэр, төрөл бүрийн хэмжээ нь өмнөх жилд Монгол Улсад үйлдвэрлэсэн тухайн нэр, төрлийн согтууруулах ундааны 30 хувьтай тэнцэх хэмжээнээс илүүгүй байхаар заасан байна.</p> <p>Өнөөгийн байдлаар жил бүр зах зээлд нийлүүлэгдэж буй согтууруулах ундааны импортын хувь хэмжээ нэмэгдэж байгаагийн зэрэгцээ согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг дамжуулан ашиглуулах, хариу төлбөртэйгээр ашиглуулах зэргээр үндсэн импортлогчдоос гадна импортын бизнес сонирхогч этгээдүүд тус салбарт үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн тоо хэмжээг урьдчилж мэдэх, хязгаарыг тогтоохын тулд дэлхийн улсуудын жишгийг харгалзан үзэх нь зүйтэй юм.</p> <p>Тухайлбал, ОХУ-ын хувьд, импортоор оруулж ирэх согтууруулах ундааны тоо хэмжээнд ногдох татвар, төлбөрөө зохих хэмжээгээрээ төлсөний үндсэн дээр "онцгой албан татварын тэмдэг буюу акц"-ыг урьдчилан худалдан авч, экспортлогч улс руу илгээн, нийлүүлэх бүтээгдэхүүнд акцыг нааж үйлдвэрлүүлэн нийлүүлдэг байх жишээтэй.</p> <p>Монгол улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд аливаа импортын хязгаарлалтыг хэрэгжүүлэхгүй байх үүрэг хүлээдэг тул хувь хэмжээ заасан хориглолт тавихын оронд ОХУ-ын дээрх жишгийг хэрэгжүүлж,</p>	<p>4.Импортлох согтууруулах ундааны хэмжээнд квот тогтоох заалт хасагдсан болно.</p>
--	--	---	--

	<p>дараах агуулгаар өөрчлөн найруулах саналтай. Үүнд:</p> <p>"Импортлохоор төлөвлөж буй согтууруулах ундааны нэр, төрөл бүрийн хэмжээг өмнөх жилд нь тооцон, холбогдох татвараа урьдчилан төлж, онцгой албан татварын тэмдгийн үнийг төлсөнөөр баталгаажуулан тогтооно" гэх саналтай байна.</p> <p>5.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2-д "Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна:</p> <p>17.2.1. 11 -22 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх;</p> <p>17.2.2. 14-04 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх." гэж заажээ.</p> <p>Согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарыг тогтоохдоо үйлчилгээний цаг урт байх тусам "үйлчлэх тусгай зөвшөөрөл"-ийн тэмдэгтийн хураамж, төлбөр өндөр байхаар эдийн засгийн утгаар нь ангилах саналтай байна. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> <li>• 11.00-22.00 цаг хүртэл үнэ төлбөргүй;</li> <li>• 22.00-00.00 цаг хүртэл төлбөртэй</li> <li>• 22.00-02.00 цаг хүртэл дээрхээс ялгамжтай төлбөртэй;</li> <li>• 22.00-04.00 цаг хүртэл дээрхээс ялгамжтай төлбөртэй гэх зэргээр тусгах нь үйлчилгээ эрхлэгчдийг хариуцлагажуулах, архи дан согтуурахтай тэмцэх, түүний сөрөг үр дагавраас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой юм. Ялгаатай цагийн хуваарьт ажиллах үйлчилгээний газрын стандарт, тавигдах шаардпагууд, хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч зэрэг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс тогтоохоор эрх олгох саналтай байна.</li> </ul> <p>5/Төслийн 25 дугаар зүйлийн 25.1-д Хуульд өөрөөр заагаагүй бол 00-11 цагийн хооронд согтууруулах ундаа худалдахыг хориглохоор заасан нь татваргүй барааны дэлгүүрийн горимыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах тул төслийн 25 дугаар зүйлд дараахь агуулгаар заалт нэмэх саналтай байна:</p> <p>"25.4.Энэ хуулийн 25.1 дэх заалт татваргүй барааны дэлгүүрийн горимд хамаарахгүй."</p> <p>Түүнчлэн цагийн хязгаарыг хуулиар хатуу тогтоох нь хориглосон цагт зөвшөөрөлгүй, хууль бус, хуурамч согтууруулах ундаа худалдаалагдах, "саарал"</p>	<p>5.Тусгай зөвшөөрлийн төрлийг тогтоохтой холбоотой зохицуулалтыг төслийн 17 дугаар зүйлд, үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарьтай холбоотой зохицуулалтыг 25 дугаар зүйлд өөрчилж тусгасан.</p>
--	--	---

		<p>зах зээлийг хөгжүүлэх эрсдэлтэй байдгийг анхаарч, хориглосон цагт түүнтэй хэрхэн тэмцэхийг хуульд тусгайлан оруулах саналтай байна.</p> <p>6.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3-т Соггууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савлагаатай нь худалдах, түүгээр үйлчлэхийг хориглохоор заасан нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан эрүүл ахуй, ариун цэврийн норм стандартад заасан, зориулалтын, эрүүл ахуйн шаардлага хангасан савлагаанд савлагдсан байх шаардлагыг хангахгүй байх эрсдэлтэй юм.</p> <p>Түүнчлэн согтууруулах ундаагаар үйлчлэх эрх бүхий газарт архи, виски зэрэг хатуулаг өндөртэй бүтээгдэхүүнээр жижиглэнгээр үйлчлэх тохиолдолд савлагааг өөрчилснөөр хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хэрэглэгчдийн зүгээс өөрийн захиалсан бүтээгдэхүүн мөн эсэхэд эргэлзээ төрүүлэх, магадгүй хямд, эсхүл хуурамч, хууль бус согтууруулах ундаагаар сольж үйлчлэх, улмаар иргэдийн эрүүл мэнд, амь насанд ч аюултай нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй юм. Согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлах зохицуулалтыг оновчтой тогтоохгүй бол хар тамхи, мансууруулах бодисны хэрэглээ далд хэлбэрээр хөгжих эрсдэлтэй.</p> <p>Иймд төслийн 26.3-ыг хасах саналтай байна.</p> <p>7.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулахыг хориглохоор заасан нь Зар сурталчилгааны тухай хуулийн 14<sup>1.4</sup>-т “18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архийг үйлдвэрлэгч, борлуулагч аж ахуйн нэгж нь нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих зорилгоор ивээн тэтгэсэн, санхүүжүүлсэн, хандив өгсөн бол уг арга хэмжээг зохион байгуулж байгаа газарт тухайн бүтээгдэхүүнээ сурталчилсан ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад сурталчилгааны хэрэгслийг байрлуулж болно.” гэж заасантай нийцэхгүй байгаа тул төслийг дараахь агуулгаар өөрчлөн найруулах саналтай байна. Үүнд:</p> <p>Төслийн “32.1.1.3.Зар сурталчилгааны тухай хуулийн 14<sup>1.4</sup>-т зааснаас бусад тохиолдолд аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах”.</p> <p>8.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.4-т согтууруулах ундаагаар дээж, загвар</p>	<p>6.Саналыг авах боломжгүй. 35аас дээш хувийн хатуулагтай согтууруулах ундааг хундагалж үйлчлэх нь олон улсад хэрэгждэг үйлчилгээний стандарт.</p> <p>7.Согтууруулах ундаа сурталчлахгүйгээр ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх боломжтой.</p> <p>8.Зохицуулалт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хооронд үүсэх бүтээгдэхүүн танилцуулах харилцаанд хамаарахгүй бөгөөд зөвхөн согтууруулах ундаа хуралдах, түүгээр үйлчлэх тусгай</p>
--	--	---	--



		<p>хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчлэх, бусдыг дайлах, амталгаа зохион байгуулахыг хориглохоор заасныг дараахь үндэслэлээр хасах, эсхүл доорх агуулга, хүрээнд өөрчлөн найруулах саналтай байна:</p> <p>“согтууруулах ундаагаар дээж, загвар хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчлэх” гэсэн хэсэг нь төслийн 32 дугаар зүйлийн 32.1.3-д заасан “согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч согтууруулах ундаагаар бусдад үнэ төлбөргүй үйлчлэх” гэж заасантай давхцсан;</p> <p>“бусдыг дайлах” гэсэн нь иргэд хоорондын харилцаанд ч үйлчлэхээр ойлгогдож байгаа бөгөөд энэхүү харилцааг хянах боломжгүй юм;</p> <p>“амталгаа зохион байгуулах” ажиллагаа нь дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдааны үеэр хийгддэг эцсийн хэрэглэгчдэд бус стратегийн хөрөнгө оруулагч, экспортын түншлэгч нарт зориулан хийгддэг ажиллагаа бөгөөд энэ хүрээнд байвал зохих ажиллагаа юм.</p> <p>9.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.6-д согтууруулах ундааг зээлээр худалдах, зээлээр үйлчлэхийг хориглохоор заажээ.</p> <p>Согтууруулах ундааг зээлээр худалдах, худалдан авах гэрээ нь үйлдвэрлэгч болон агентаас согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд бөөний борлуулалт хийх харилцаанд түгээмэл ашиглагддаг бөгөөд талуудын арилжааны гэрээний гол нөхцөлөө тохиролцох эрхийн хүрээнд хэрэгждэгийн зэрэгцээ Иргэний хуульд заасан иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын гэрээний эрх чөлөөний зарчимд нийцэж байгаа болно.</p> <p>Иймд төслийн 32.1.6-г согтууруулах ундаа худалдах, үйлчлэхдээ эцсийн хэрэглэгчдэд зээлээр худалдах, үйлчлэхийг хориглох дараахь агуулгаар өөрчлөн найруулах нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцнэ гэж үзэж байна. Үүнд:</p> <p>“32.1.6.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь согтууруулах ундааг зээлээр худалдах, үйлчлэх.”</p> <p>10.төслийн 32 дугаар зүйлийн 32.1.11-д эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэхийг хориглохоор заасан байна.</p> <p>Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий газарт хэрэглэгчийн захиалсан бүтээгдэхүүнийг тухайн нэр төрлийн барааны тэмдэг, дүрс, лого бүхий эд бараа, шилэн аяга, дагалдах хэрэглэлийн хамтаар үйлчлэх нь үйлчилгээний стандарт, соёл, хэрэглэгчийн хүсэл таашаалд нийцдэг.</p>	<p>зөвшөөрөлтэй этгээд болон хэрэглэгчид хамаараалтай зохицуулалт юм.</p> <p>9.“Эцсийн” хэрэглэгч, үйлчлүүлэгчид зээлээр худалдаж үйлчлэхийн хориглоно.</p> <p>10.санал туссан. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгөөс бусад газарт эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон</p>
--	--	--	--

		<p>Түүнчлэн олон улсын практикт дэлхийн тэргүүлэх брэндүүд эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундааны нэр, тэмдгийг хэрэглэсээр байгаа бөгөөд түүнийг согтууруулах ундаанаас бусад төрлөөр барааны тэмдгээр баталгаажуулан авч хувцас, хэрэглэлд хэрэглэж байна. Тухайлбал, Европын холбооны хөл бөмбөгийн Аваргуудын лигийн ивээн тэтгэгчээр Хейнекен шар айраг, Германы Бундеслигийн ивээн тэтгэгчээр Будвейзер шар айрагны брэнд хамтран ажиллаж, тамирчдын хувцас, хэрэглэлд өргөнөөр ашигладаг.</p> <p>Иймд төслийн 32.1.11-ийг дараахь агуулгаар өөрчлөн найруулах саналтай байна. Үүнд:</p> <p>“32.1.11.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад газарт эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх.”</p> <p>Хуулийн төсөлд үйлдвэрлэгч, борлуулагч, худалдаа, үйлчилгээ эрхлэгчид зэрэг бүхий л талуудын төлөөллийн саналыг авч, удаа дараагийн хэлэлцүүлэг хийн, хуулийн төсөлд тусгах нь архидан согтуурахтай тэмцэх, түүний нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавар, шалтгаан нөхцөлийг багасгах, “саарал” зах зээлээс урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилт үр дүнтэй байх зэрэг олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.</p>	<p>согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэхгүй байхаар тусгасан.</p>
25.	Монголын хөл бөмбөгийн холбоо 2020.10.12 02/356	<p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцан, хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д “аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах;”-ыг хориглоно гэсэн заалтын “аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх” хэсгийг хасах эсвэл 32.1.1 заалтыг бүхэлд нь хасах саналтай байна.</p> <p>Учир нь хөл бөмбөгийн спорт ба түүний хөгжил нь бага хатуулагтай согтууруулах ундаа буюу шар айрагтай салшгүй холбоотой билээ. Дэлхий даяар хөл бөмбөгийн холбоод, багууд, лигийн тэмцээн уралдаан, арга хэмжээнүүд шар айраг үйлдвэрлэгчидтэй нягт холбоотой хамтран ажилладаг. Монголын Хөл Бөмбөгийн</p>	<p>Санал туссан болно.</p>

		<p>Холбооны хувьд ч мөн адил энэхүүхамтын ажиллагаа, санхүүгийн дэмжлэг их чухал ач холбогдолтой байдаг. Монголын хөл бөмбөг, багууд болон тамирчдын хөгжилд, ур чадварыг нь дээшлүүлэхэд согтууруулах ундаа үйлдвэрлэгчид их хувь нэмэр оруулдаг. Үндэсний шигшээ баг, үндэсний дээд лигийн болон сонирхогчийн багуудыг дэмжиж, өдөр тутмын бэлтгэл сургуулилтаа явуулах боломжоор хангахад дэмжлэг үзүүлэн ирсэн. Монголын Хөл бөмбөгийн Үндэсний шигшээ баг Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилан шалгаруулалтад амжилттай оролцож, 2-р шатанд шалгаран тоглож байгаа нь үүнийг мөн батална гэж итгэж байна. Мөн 2021 онд бид Азийн Эмэгтэйчүүдийн Аварга Шалгаруулах Тэмцээнийг өөрийн оронд зохион байгуулахаар ажиллаж байгаагаа үүнд дурдахыг хүсч байна.</p> <p>Түүнчлэн хөл бөмбөгийн спортыг үзэгч хөгжөөн дэмжигч наргүйгээр төсөөлөхийн аргагүй бөгөөд дэлхийн ихэнхи улс орнуудад хөл бөмбөгийн тэмцээний үеэр хатуулга багатай согтууруулах ундааг худалдаалах, зохистой хэрэглээг тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрдөг тул хөл бөмбөгийн болон бусад тэмцээний үеэр хатуулга багатай согтууруулах ундааг худалдаалах боломжтой байдлаар хуулийн төсөлд тусгаж өгөхийг хүсье.</p>	Санал туссан болно.
26.	Монголын эмэгтэйчүүдийн холбоо 2020.09.29 02/100	<p>17-р зүйл 2.2 14-12 цагхүртэл архи согтууруулах ундаагаар үйлчлэх</p> <p>22-р зүйл. 1.7 Хасах буюу орон сууц болон ойролцоо архи, согтууруулах ундаа зарах, үйлчлэхгүй байх</p> <p>33-р зүйл. Нэмэлт санал... Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх телевиз радио улиралд нэг удаа архины хор хохирлын талаар нэвтрүүлэг хийх</p> <p>36-р зүйл. Нэмэлт санал... Албадан эрүүлжигдэж байгаа этгээдэд архины хор хохирлын талаар сургалт явуулах</p> <p>38-р зүйл. Нэмэлт санал ... Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хуулийн этгээд болгон архины хор хохирлын талаар ажилчиддаа улиралд нэг удаа сургалт явуулах үүрэгтэй.</p> <p>Хуучин хуулийн 13-р зүйлийг буцааж оруулах... Нэмэлт санал... Архинаас олж буй орлогын тодорхой хувийг архидалттай тэмцэхэд зарцуулах</p>	<p>Санал хэсэгчлэн туссан болно.</p> <p>Санал зарчмын хувьд хуулийн төсөлд агуулагдаж байгаа болно.</p> <p>Санал туссан. Засгийн газрын тусгай сан байгуулахаар хуулийн төслийг дагалдан</p>

			гарах Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд туссан болно.
27.	Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ 2020.10.01 20/10/42	<p>Дараах саналтай байна.</p> <p>1.Төслийн 16.7-д согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийг хариу төлбөртэйгөөр ашиглуулахыг хориглохоор заасан нь Нийслэлийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 5000 орчим жижиг бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хөндөж байгаа бөгөөд олон мянган ажлын байр эрсдэлд орох, 8 нэрийн дэлгүүр гэх мэт олон мянган аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, дампуурах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал, бидний судалгаанаас үзэхэд ийм төрлийн бизнес эрхлэгчдийн 80 орчим хувь нь түрээсийн байранд үйл ажиллагаагаа эрхэлж согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл авсан байдаг байна. Иймд төслийн 16 дугаар зүйлийн 16.7-ын “хариу төлбөртэйгээр ашиглуулах” гэснийг хасах саналтай байна.</p> <p>2.Төслийн 22.1.3-ын холбогдох хэсгийг “шөнийн 00.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл согтууруулах ундааг шатахуун түгээх газарт худалдах, цагийн хязгаарлалтаас үл хамааран шатахуун түгээх газарт согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох агуулгаар өөрчлөн найруулах саналтай байна.</p> <p>3.Төслийн 22.1.7-ын “анх батлагдсан зураг төсөл нь” гэснийг хасах саналтай байна.</p> <p>4.Төслийн 23.1.5, 23.1.6-ыг тодорхой хэмжээ, хязгаар тавьсны үндсэн дээр онлайнаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлүүлэх нөхцөлийг зөвшөөрөх агуулгаар өөрчлөн найруулах саналтай байна.</p> <p>5.Согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарыг хуулиар хатуу тогтоох нь хориглосон цагт хууль бус худалдаа, хуурамч бүтээгдэхүүн худалдаалагдах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй бөгөөд цагийн хязгаарыг тогтоох эрхийг одоогийн хуулиар тогтоож байгаатай адилаар аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагчид хадгалагдахаар тусгах саналтай.</p> <p>Согтууруулах ундаагаар үйлчлэх эрх бүхий газарт архи, виски зэрэг хатуулаг өндөртэй бүтээгдэхүүнээр жижиглэнгээр үйлчлэх тохиолдолд савлагааг өөрчилснөөр хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хэрэглэгчдийн зүгээс өөрийн</p>	<p>Санал туссан. Тусгай зөвшөөрлийг хариу төлбөртэйгөөр ашиглуулах заалтыг хассан болно.</p> <p>Саналыг авах боломжгүй.</p> <p>Зөвхөн энэ төрлийн үйлчилгээ эрхлэгч этгээдийн эрх ашиг энд хөндөгдөөгүй бөгөөд нийтийн эрх ашгийг харгалзан саналыг авах боломжгүй гэж үзсэн.</p> <p>Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй этгээд болон худалдан авагч биечлэн харьцаж худалдах онцгой бүтээгдэхүүн тул хэрэглэгчид худалдах тохиолдолд</p>

		<p>захиалсан бүтээгдэхүүн мөн зсэхэд эргэлзээ төрүүлэх, магадгүй хямд, эсхүл хуурамч, хууль бус согтууруулах ундаагаар сольж үйлчлэх, улмаар иргэдийн эрүүл мэнд, амь насанд ч аюултай нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй юм. Иймд төслийн 26.3-ыг хасах саналтай байна.</p> <p>6.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий газарт хэрэглэгчийн захиалсан бүтээгдэхүүнийг тухайн нэр төрлийн барааны тэмдэг, дүрс, лого бүхий эд бараа, шилэн аяга, дагалдах хэрэглэлийн хамтаар үйлчлэх нь үйлчилгээний стандарт, соёл, хэрэглэгчийн хүсэл таашаалд нийцдэг. Иймд төслийн 32.1.11-ийг “32.1.11.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгөөс бусад газарт эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх.” гэж өөрчлөн найруулах саналтай байна.</p>	<p>цахимаар хэлцэл хийхийг зөвшөөрөх боломжгүй.</p> <p>Цагийн хязгаартай холбоотой санал туссан болно.</p> <p>35 хувиас дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг савалгаатай нь худалдаж үйлчлэхгүй гэдэг нь зөвхөн согтууруулах ундаагаар үйлчлэх этгээдэд хамааралтай бөгөөд 35-аас дээш хувийн хатуулагтай спирт агуулж буй согтууруулах ундааг хундагалаж үйлчлэх нь гадаадын олон улсад хэрэгждэг үйлчилгээний стандарт тул саналыг авах боломжгүй гэж үзэв.</p> <p>Саналыг тусгасан болно.</p>
28.	<p>Монгол дахь Америкийн Худалдааны Танхим</p> <p>2020.09.28 2020/41</p>	<p>Манай танхимын согтууруулах ундаа худалдан борлуулагч гишүүдийн зүгээс дээрх хуулийн төслийн талаар дараах саналуудыг гаргаж байна. Үүнд:</p> <p>1.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд ил болгож, холбогдох оролцогч талууд тухайлбал архи, согтууруулах ундаа үйлдвэрлэгчид төлөөлөгчид худалдааны холбоод зэрэг холбогдох талууд болон Дэлхийн худалдааны байгууллагад TBT/SPS сувгуудаар дамжуулан албан ёсоор мэдэгдэнэ гэж найдаж байна.</p> <p>2.Бид хуулийн төсөлд олон нийтээс санал хүлээн авах хугацааг энэ оны 10-р сарыг дуустал сунгаж өгнө үү хэмээн хүсч байна. Энэ хугацаанд бид хязгаарлалт багатай,</p>	

	<p>олон улсын сайн туршлага дээр үндэслэсэн өөр хувилбар, шийдлүүдийг танд санал болгох хүсэлтэй байна. Тухайлбал насанд хүрээгүй хүүхдийн онлайн архины худалдааг хэрхэн хязгаарлах г.м.</p> <p>3.Бидний зүгээс одоо мөрдөгдөж байгаа лиценжүүлэх шаарлагуудыг дэмжиж байгаа боловч, нэг жилд импортлох согтууруулах ундааны нэр, төрөл бүрийн хэмжээ нь өмнөх жилд Монгол Улсад үйлдвэрлэсэн тухайн нэр, төрлийн согтууруулах ундааны 30 хувьтай тэнцэх хэмжээнээс илүүгүй байна гэсэн заалтыг эргэн харна уу хэмээн хүсч байна. Энэ нь бизнес эрхлэгчдийн цаашдын зах зээлийн эрэлтийг хангах чадварт сөргөөр нөлөөлж, хууль бус импорт ихсэж, татварын орлогын алдагдалд хүргэх болно</p> <p>4.Хуулийн төсөл нь танай яам, хууль сахиулах байгууллагууд, согтууруулах ундаа борлуулагчид, зоогийн газар, баар, салбар, олон нийт зэрэг бүхий л оролцогч талуудын хамтын хүчин чармайлтаар дэмжигдсэн тохиолдолд л үр дүнтэй бөгөөд урт хугацааны зан үйлийн өөрчлөлтийг бий болгодог. Тиймээс олон талт оролцогчдын хэлэлцүүлэгт үндэслэн шийдвэр гаргах нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийг амжилттай хэрэгжүүлэх бодит замын зураглал, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад чухал ач холбогдолтой гэж бид үзэж байна. Хуулийн энэхүү төслийг хэд хоног эсвэл долоо хоногийн дотор яаравчлуулж болохгүй.</p> <p>5.Түүнчлэн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөлд дараах саналуудыг эхний байдлаар тусгуулах хүсэлтэй байна.</p> <p>Үүнд:</p> <p>6.Борлуулалт болон нийлүүлэлтийг хязгаарлах заалтууд 16.2, 22.1, 26.3 - Архи борлуулах цагийн заалт, сургууль, барилгаас 100 метр зайд архи дарс борлуулахыг хориглох, 35%-иас дээш этилийн спирттэй архи худалдахыг хориглох зэрэг заалтууд нь пропорциональ бус, хэрэгжүүлэхэд хэцүү юм. Энэ нь ресторан, баар, үйлчилгээний салбарт сөргөөр нөлөөлнө.</p> <p>7.23.1.5 - 6-р зүйлийн цахим худалдаа, онлайн худалдаа, апп-ын борлуулалт, хүргэлтийг хориглох заалтууд - Засгийн газар онлайн зах зээлд үр дүнтэй зохицуулалтыг онцолж байгаа боловч, хамгийн сайн зохицуулалт нь онлайн ба онлайн бус операторууд архи зарах зөвшөөрөл, худалдан авагчын насыг шалгах,</p>	<p>2. Төсөлд санал авах хугацааг сунгасан болно.</p> <p>3.Импортын бүтээгдэхүүнд квот тогтоох заалтыг хассан болно.</p> <p>4.хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг 2020 оны 9 дүгээр сарын 11 өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны веб сайтад байршуулж бичгээр санал авсан.</p> <p>6.Хэрэгжих боломжтой гэж үзсэн.</p> <p>7.Саналыг авах боломжгүй. Согтууруулах ундаа худалдагч болон худалдан авагч биечлэн харьцаж худалдах онцгой бүтээгдэхүүн тул жижиглэн</p>
--	---	---

		<p>болон бусад шаардлагуудыг нягтлах юм. Үгүй бол одоогийн онлайн худалдаа нь далд болон хувирч, засгийн газар, хэрэглэгчид, албан ёсны борлуулагчдын эрх ашгийг хөндөнө. Зохицуулалттай онлайн худалдаа нь хангамжын сүлжээний удирдлагыг дэмжиж, зах зээлийн хэмжээ, хандлагыг тодорхойлох, насанд хүрээгүй хүүхдэд архи зарах хүргэж өгөх зэргээс сэргийлэх, үнэмлэх батаглаажуулалт, хууль бус худалдааны эсрэг хамгийн зөв хэмжээ болж чадна.</p> <p>8.32.1.3-4 заасны дагуу зарим зар сурталчилгаа, маркетинг (амталгааг) хориглох - Хууль ёсны согтууруулах ундаа борлуулагчид нь насанд хүрсэн хүн согтууруулах ундааг худалдан авахаасаа өмнө тухайн бүтээгдэхүүнийг үнэгүй амталж үзэх боломжоор хангадаг бөгөөд энэ нь согтууруулах ундааны хариуцлагагүй зан үйлд хүргэдэг гэсэн нотолгоо байхгүй. Насанд хүрээгүй хүмүүст согтууруулах ундааг сурталчилж, маркетинг явуулахаас сэргийлэхийн тулд олон улсын компаниуд насанд хүрээгүй хүмүүст сурталчилгаа хийх, согтуугаар жолоо барих, жирэмсний үед архи хэрэглэх г.м-ийн эсрэг нарийн арга хэмжээ авах талаар өөрийгөө хуульчилсаар ирсэн. Энэхүү салбарын хувьд өөрийгөө хуульчлах явдал нь Монгол улсын хувьд анхны алхам гэж тооцогдоно.</p> <p>9.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдрүүдийг тогтоох тухай 24.1.р заалт болон 26.3-4-р заалтууд: Эдгээр заалтууд нь газар дээр нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, албан ёсны борлуулагчид болон зочлох үйлчилгээ эрхлэгчдэд нэмэлт зардал үүрүүлж байна. Түүнчлэн 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савлагаатай нь худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай заалт нь үйлдвэрлэл эрхлэгчдийг ялгаварлаж буй мэт тооцогдохоор байгаа бөгөөд учир нь энэ хязгаарлалт дотоодын (дийлэнх нь шар айраг) бүтээгдэхүүнээс илүүтэй импортоор оруулж ирж буй бүтээгдэхүүнд илүү нөлөө үзүүлэхээр байна.</p>	<p>худалдааг цахимаар хийхийг зөвшөөрөх боломжгүй. Үйлдвэрлэгч, жижиглэн худалдаа эрхлэгчдийн хоорондох харилцаанд хамаарахгүй.</p> <p>9.Архигүй өдрүүдийн тоог цөөрүүлсэн. 35 хувиас дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг савалгаатай нь худалдаж үйлчлэхгүй гэдэг нь зөвхөн согтууруулах ундаагаар үйлчлэх этгээдэд хамааралтай бөгөөд, дотоодын үйлдвэрийн болон импортын бүтээгдэхүүнд адил хамаарах зохицуулалт тул импортын бүтээгдэхүүнийг шударга бусаар хязгаарласан аливаа байдал байхгүй юм. Түүнчлэн 35-аас дээш хувийн хатуулагтай спирт агуулж буй согтууруулах ундааг хундагалж үйлчлэх нь гадаадын олон улсад хэрэгждэг үйлчилгээний стандарт юм.</p>
		<p>Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимаас 2020.09.22-ны өдөр ирүүлсэн хуулийн төсөл АНДБСДОУХ-ны санааг ихээхэн чилээж байгаа талаар байр сууриа илэрхийлье. Тус төслөөр импортын квот, биет ба цахим борлуулалтад хэт хатуу хязгаар тогтоосны зэрэгцээ зар сурталчилгаа/маркетингийн</p>	

29.	<p>Европ Монголын хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхим 2020.10.22 20200102201</p>	<p>хязгаарлалтыг нэмэгдүүлэхээр тусгажээ. Төсөл боловсруулах үндэслэлийг бид хүлээн зөвшөөрч, ойлгож байгаа боловч ийм хатуу хязгаарлалттайгаар хуульчлах аваас архины хууль бус худалдаа цэцэглэх, чанар, аюулгүй байдлын ямар ч баталгаагүй, эрүүл мэндэд хор хохирол учруулах магадлалтай бүтээгдэхүүн иргэдийн гар дээр очих эрсдэлийг зүй бусаар бий болгохын сацуу архидан согтууралтыг үр дүнтэйгээр хумьж чадахгүй гэж бид үзэж байна.</p> <p>АНДБСДОУХ бүс нутгийн хэмжээнд эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, архи хэтрүүлэн хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, насанд хүрээгүй хүмүүс согтууруулах ундаа хэрэглэснээс үүдэх сөрөг нөлөөллийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд засгийн газруудыг тогтмол дэмжиж ажилладаг. Согтууруулах ундааны борлуулалт, нийлүүлэлт, хүргэлт болон бусад үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох замаар энэ төрлийн бүтээгдэхүүний зах зээлд илүү оновчтой менежмент хийх, албан ёсоор импортолсон, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлтэй цэгүүдээс авах боломж бүрдүүлэх, арван наймаас доош насныханд согтууруулах ундаа зарах, түүгээр үйлчлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтоох, хэрэглэгчдийг хууль бус бүтээгдэхүүнээс хамгаалах чиглэл дээр Монгол улсын засгийн газартай хамтран ажиллахад тун баяртай байх болно.</p> <p>ялгавартай хандсан шинжтэйн зэрэгцээ архи хэтрүүлэн хэрэглэхийг хязгаарлах тал дээр үр дүн гарахгүй хэмээн АНДБСДОУХ-ны зүгээс үзэж буй нь дараах шалтгаантай. Үүнд:</p> <p>1. Эрх зүйн зохицуулалтын орчин хэт чангадах, ор тас хорих, хориглолт тогтоох нь хууль тогтоомжийн дагуу албан ёсоор, татвар төлсний үндсэн дээр үйлдвэрлэл эрхэлдэг хариуцлагатай салбар хөгжүүлэхийг дэмжих бус харин эсрэгээр далд эдийн засгийг цэцэглүүлнэ. Тиймээс согтууруулах ундааны зохицуулалтад удирдлага болгох хууль нь олон нийтийн эрх ашгийн төлөө согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх хорт зуршлыг бууруулах хууль ёсны зорилтыг хангах, хариуцлагагүй байгууллагуудад онож чиглэсэн зохистой харьцаа бүхий, хэрэгжих боломжтой, тодорхой байх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаагаа хууль ёсоор бизнес эрхлэгчдээ төлөөлөн өргөн мэдүүлье.</p> <p>2. Согтууруулах ундаа импортлогчдод тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг жигдэлж, стандартад оруулахыг бид бүрэн дүүрэн дэмжиж байгаа хэдий ч импортын согтууруулах ундааны нэр, төрөл бүрийн хэмжээг дотооддоо үйлдвэрлэсэн тухайн нэр, төрлийн согтууруулах ундааны 30 хувиас илүүгүй байлгах квот тогтоох нь</p>	<p>2.Импортын бүтээгдэхүүнд квот тогтоохтой холбоотой заалтыг хассан болно.</p>
-----	--	--	---



	<p>ялгавартай хандсанд тооцогдох бөгөөд тус салбарт бизнес эрхлэгчид зах зээлийн чиг хандлагад нийцүүлэн хариу арга хэмжээ авах, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах боломжгүй байдалд хүрнэ. Улмаар хуулийн дагуух нийлүүлэлт нь зах зээлийн эрэлтээ хангаж чадахгүйд хүрвэл хууль бус импорт хийгдэж улмаар татварын орлого алдагдахад хүргэнэ.</p> <p>3.Цаашилбал, 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савлагаатай нь худалдах, үйлчлэхийг хориглосон нь импортын бүтээгдэхүүнийг шударга бусаар хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд зүй бусаар давуу эрх олгох тул ялгавартай хандсан арга хэмжээ болох юм. Ийм ялгавартай хандлага нь Монгол улс 1997 оны 1-р сарын 29-ний өдөр гишүүнээр элссэн Дэлхийн Худалдааны Байгууллагын зарчимд харшилна.</p> <p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хязгаарласан 17.2, 22.1, 26.3 дахь заалтууд Орон сууцны суурийн давхар, ерөнхий боловсролын сургуулиас 100 метрийн дотор согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглож, худалдаалах цагийн хуваарьт маш хатуу хязгаарлалт тавьж, 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савлагаатай нь худалдах, үйлчлэхийг хориглосон нь зүй зохис алдагдсан, бодьгүй, хэрэгжүүлэхэд ч хүндрэлтэй заалт болжээ. Энэ нь ресторан, баар, зочлох үйлчилгээний салбарынханд мөн сөргөөр нөлөөлнө.</p> <p>4.Согтууруулах ундааг зайнаас болон өөртөө үйлчлэх автомат төхөөрөмж ашиглан эсхүл гар дээрээс худалдах, түүгээр үйлчлэх, гэрийн хаягаар хүргэхийг хориглосон 23.1.5-6 дахь заалтууд цахим зах зээлд дүрэм, журам үр дүнтэй хэрэгжих эсэхэд Засгийн газар эргэлзэж байж болохыг бид хүлээн зөвшөөрч буй ч тусгай зөвшөөрөл олгох, худалдан авагчийн насыг шалгаж баталгаажуулах түүнчлэн цахим бусаар буюу ердийн дэлгүүрийн борлуулагчдад тавьдагтай ижил шаардлагыг цахим худалдаалагчдад тавих зэргээр энэ бизнесийнхэнд оновчтой менежмент хийх нь согтууруулах ундаа хууль бусаар худалдаалахаас сэргийлэх хамгийн тохиромжтой арга байдаг. Эс бөгөөс одоогийн цахим үйл ажиллагаа далд хэлбэрт шилжих үр дагавар л үүсч, Засгийн газар, хэрэглэгчид болон хууль ёсоор бизнес эрхлэгчдийг хамгаалах ямар ч аргагүй болно</p> <p>5.Зар сурталчилгаа, амталгаа зэрэг маркетингийн зарим үйл ажиллагааг хориглосон 32.1.3-4 дэх заалтууд хууль ёсоор худалдаа эрхлэгчдийн зүгээс насанд хүрэгчдэд худалдан авалт хийхийнх нь өмнө илүү сайн ойлголт өгөх зорилгоор дээж өгөх, амсуулах зэргээр бүтээгдэхүүнээ үнэ төлбөргүй өгдөг. Эдгээр ажиллагаа согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх хорт зуршлын шууд учир шалтгаан болсон</p>	<p>3.5 хувиас дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг савалгаатай нь худалдаж үйлчлэхгүй гэдэг нь зөвхөн согтууруулах ундаагаар үйлчлэх этгээдэд хамааралтай бөгөөд, дотоодын үйлдвэрийн болон импортын бүтээгдэхүүнд адил хамаарах зохицуулалт тул импортын бүтээгдэхүүнийг шударга бусаар хязгаарласан байдал байхгүй юм.</p> <p>4.Саналыг авах боломжгүй. Согтууруулах ундаа нь худалдан авагч болон худалдагч биечлэн харилцаж тодорхой нөхцлүүдийг тодруулсны тухайлбал нас, үндсэн дээр худалдах онцгой бүтээгдэхүүн тул зайнаас болон өөртөө үйлчлэх төхөөрөмжөөр худалдах үйл ажиллагааг зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.</p> <p>5.Төслийн 32.1.4 дэх заалт нь согтууруулах унда худалдах болон түүгээр үйлчлэх этгээдэд хамааралтай бөгөөд</p>
--	--	--

		<p>гэх нотолгоо үгүй.</p> <p>6.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдрийн тоог нэмэгдүүлсэн 24.1 дэх заалт, өөр бусад шаардлагууд тогтоосон 26.3-4 дахь заалтууд эдгээр санал үйл ажиллагааны түвшинд бодит биелэл болох магадлал багатай. Харин ч эсрэгээр, хууль ёсны худалдаа эрхлэгчид, хоол хүнс, ундаа, зочид буудлын үйлчилгээнийхэнд зохисгүй хэмжээгээр нэмэлт зардлын дарамт болно.</p> <p>Татваргүй барааны дэлгүүрүүдийн тоо, импортлон оруулж ирж байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээнд хязгаар тавих талаар хуульд тусгаж өгөх.</p>	<p>үйлдвэрлэгч нарт хамаарахгүй юм.</p> <p>6.24 дүгээр зүйлд заасан “Согтууруулах ундаагүй” өдрийн тоог цөөрсөн 26.3-т заасан үйлчилгээний газарт 35 хувийн хатуулагтай спирт агуулсан согтууруулах ундааг зөвхөн хундагалаж үйлчлэх болон ундны усаар үнэ төлбөргүй үйлчлэх нь согтууруулах ундаагаар үйлчлэх этгээдэд хамааралтай бөгөөд энэ бол гадаадын олон улсад мөрддөгддөг үйлчилгээний стандарт юм.</p>
30.	Монголын сав баглаа, боодол үйлдвэрлэгчдийн холбоо 2020.10.5 20/29	Хуулийн төслийн 13.3-т Гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд 18-аас дээш хувийн этилийн спирт агуулж байгаа согтууруулах ундааг 0,33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр болон хуванцар сав /лонх/-нд савлахыг хориглохоор заасныг хасах санал хүргүүлж байна.	Саналыг авах боломжгүй болно.
31.	Иргэн Эрдэнэ Доржнамжим 2020.09.24 Tusul@mojha.gov.mn	МУ ЗГ архидан согтуурахтай тэмцэж байгаад талархаж байна. Иргэн хүний хувьд бага насны хүүхдүүд архи уух, түүнд донтох, сургуулийн гадаа пиво уух явдал маш их байгаад санаа их зовож байна. Цаашлаад хар тамхинд донтох, хэрэг түвэгт орооцолдох гээд аюул нүүрлээд удаж байна. Сүүлд гарсан судалгаагаар 3 сая иргэн жилд 10 сая шил архи уудаг гэж гарсаныг саяхан цахим сүлжээнээс олж уншаад айдас хүүдэс хүрч байна. Иймд "ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор АРХИ СОГТУУРУУЛАХ ундааг худалдах"-ыг хориглох заалт оруулж өгөхийг хүсье.	Саналыг анхаарсан болно.

32.	Ази, Номхон Далайн бүсийн спирт, дарсны олон улсын холбоо /APISWA/  2020.10.05	Монгол дахь Америкийн худалдааны танхим, Европ Монголын хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхимаар саналаа ирүүлсэн. Холбогдох хэсгийг үзэх.	Монгол дахь Америкийн худалдааны танхим, Европ Монголын хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхимын холбогдох хэсгийг үзэх.
33.	Монголын хуульчдын холбоо 2020.10.01 1/815	Зарчмын хувьд дэмжиж байна.	Хуулийн төслийг дэмжсэн.